

**ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ШИНЭЧЛЭН НАЙРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ,
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН СУДАЛГАА**

**УЛААНБААТАР
2024 ОН**

АГУУЛГА

АГУУЛГА	1
Удиртгал.....	2
НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ.....	3
1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал.....	12
1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох:	13
1.3. Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох:	14
ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ	14
ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН ХАРЬЦУУЛАЛТ	14
3.1. Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах:	14
3.2. Хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулга, сурталчилгааны ажил өрнүүлэх хувилбар	15
3.3. Зах зээлийн эдийн засгийн хэрэгслийг ашиглан төрөөс зохицуулах хувилбар.....	15
3.4. Төрөөс санхүүгийн интервенц хийх хувилбар:	15
3.5. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх хувилбар:	15
3.6. Захиргааны шийдвэр гаргах хувилбар:	16
3.7. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар:.....	16
3.8. Асуудлыг шийдвэрлэх хувилбаруудын харьцуулалт	16
ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ.....	17
4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө:	18
4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө:.....	19
4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө:	22
4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө:.....	24
4.5.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх:	26
ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ	26
ЗУРГАА. ТУХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА	26
ДОЛОО. Зөвлөмж	39

Удиртгал

Даатгалын тухай хуулийг анх 1997 онд, хуулийн шинэчилсэн найруулгыг 2004 онд тус тус баталж, хүчин төгөлдөр мөрдөж байгаа хэдий ч олон улсын болон хөгжлийн чиг хандлага, даатгалын салбарын цар хүрээ, нийгэм эдийн засагт үзүүлэх үүрэг оролцоог нэмэгдүүлэхтэй холбоотойгоор даатгалын эрх зүйн орчныг шинэчлэх зайлшгүй шаардлага бий болоод байна.

Монгол улсын дараах бодлогын баримт бичгүүдэд даатгалын салбарыг хөгжүүлэх, хууль эрх зүйн орчныг өөрчлөх хүрээнд доорх зорилтуудыг тусгасан байна. Үүнд:

1. “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого
 - 2021-2030 онд даатгалын салбарын хувьд хүрэх үр дүнг “Даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах хууль, эрх зүйн орчин бүрдэж, салбарын хамрах хүрээг нэмэгдүүлсэн байна”;
 - тус бодлогын баримт бичгийн 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.3.8. Урт хугацааны даатгалын үйл ажиллагааны хууль, эрх зүйн орчныг сайжруулан, хүртээмжийг нэмэгдүүлнэ;
 - 4.3.9. Давхар даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно;
 - 4.3.10. Технологид суурилсан даатгалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно;
2. “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
 - Дотоодын давхар даатгал хөгжих, урт хугацааны даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж, даатгалын салбарын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулан салбарын тогтвортой өсөлтийг бүрдүүлнэ;
3. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” батлах тухай УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралт
 - 42. Монгол Улсад даатгалын салбарыг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх, даатгалын салбарын цахимжилттай холбоотойгоор дотоодын давхар даатгагчийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, төрийн байгууллага болон даатгалын салбарын оролцогчдын хамтын ажиллагааг уялдуулах, үйл ажиллагааны зохицуулалтыг тодорхойлох, даатгалын салбарын хяналтын тогтолцоог тодорхой болгож шинэчлэх, даатгалын сангийн хөрөнгийн менежментийг дэлхий нийтийн чиг хандлагад нийцүүлэн томоохон хөрөнгө оруулагч болоход дэмжлэг үзүүлэхэд холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

Иймд Даатгалын тухай хуулийг шинэчлэн найруулах хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”¹-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

¹ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт.

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Монгол Улсад 2023 оны жилийн эцсийн байдлаар ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 2, давхар даатгалын 1, даатгалын зуучлагч 63, даатгалын хохирол үнэлэгч 24 компани, 2416 даатгалын төлөөлөгч даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байна.

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 2019-2023 оны хооронд дунджаар жилийн 10.9 хувиар өсч, 551.4 тэрбум төгрөгт хүрээд байгаа бөгөөд нийт хөрөнгийн 85.1 хувийг ердийн даатгалын компаниуд, 11.9 хувийг давхар даатгалын компани, 2.9 хувийг урт хугацааны даатгалын компани тус тус эзэлж байна.²

Даатгалын хураамжийн орлого 2019-2023 оны хооронд жилд дунджаар 19.5 хувиар өсч 398.7 тэрбум төгрөгт хүрсэн ба ердийн даатгалын компаниуд нийт хураамжийн орлогын 97.5 хувийг, урт хугацааны даатгалын компани 0.8 хувийг, давхар даатгалын компани 1.7 хувийг тус тус бүрдүүлээд байна. Ердийн даатгалын компаниудын нийт хураамжийг даатгалын хэлбэрээр авч үзвэл, хөрөнгийн даатгал 22.5 хувийг, жолоочийн хариуцлагын даатгал 12.1 хувийг, авто тээврийн хэрэгслийн даатгал 24.2 хувийг, гэнэтийн осол, эмчилгээний даатгал 14.5 хувийг тус тус эзэлж байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар ердийн даатгалын компаниуд 1,544,754 даатгалын гэрээг байгуулж ажилласан бөгөөд үүнээс дийлэнх хувь буюу 52.6 хувийг жолоочийн хариуцлагын даатгал, 15.1 хувийг гэнэтийн осол, эмчилгээний даатгал, 11.6 хувийг хөрөнгийн даатгалын гэрээ тус тус эзэлж байна.

Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөр 2019-2023 оны хооронд жилд дунджаар 17.9 хувь, өмнөх оны мөн үетэй харьцуулахад даруй 34.2 хувиар өсч 126.7 тэрбум төгрөгт хүрсэн ба ердийн даатгалын компаниуд нийт нөхөн төлбөрийн 98.0 хувийг, урт хугацааны даатгалын компани 2.0 хувийг тус тус бүрдүүлээд байна.

Манай улсын даатгалын салбарт тодорхой ахиц дэвшлүүд гарч, санхүүгийн голлох үзүүлэлтүүд өссөн байгаа хэдий ч ерөнхийд нь дүгнэвэл даатгалын салбарын өсөлт удаашралтай буюу хангалттай бус байна. Тухайлбал, олон улсад даатгалын салбарын хөгжлийг тухайн орны даатгалын гүнзгийрэлт болон даатгалын нягтрал ямар түвшинд байгаагаар хэмжиж, харьцуулдаг бөгөөд тэдгээр үзүүлэлтүүд нь Монгол Улсын хувьд дараах байдалтай байна. Үүнд:

1. Даатгалын гүнзгийрэлт буюу дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх даатгалын хураамжийн орлогын хувь хэмжээг 2010-2020 оны хооронд авч үзвэл хамгийн багадаа 0.33, хамгийн өндөр нь 0.57, дунджаар 0.48 хувь тус тус байна³. Харин сүүлийн 5 жилийн хугацаанд авч үзвэл дунджаар 0.56 хувь байгаа бөгөөд энэ нь Swiss re байгууллагын гаргасан 2019 оны судалгаан дахь хөгжиж буй орнуудын даатгалын гүнзгийрэлтийн дундаж үзүүлэлт болох 3.3 хувьтай харьцуулахад 5-6⁴

² Санхүүгийн зохицуулах хороо, Даатгалын салбарын 2023 оны үйл ажиллагааг нэгдсэн танилцуулга, 2024.

³ Санхүүгийн зохицуулах хороо, Даатгалын салбарын 2010-2020 оны 4-р улирлын үйл ажиллагааны нэгдсэн танилцуулгуудаас шаардлагатай тоон мэдээллүүдийг түүвэрлэж, боловсруулав. <http://frc.mn/data/tailan?c=310> холбоосоор харна уу.

⁴ World insurance: Regional review 2019, and outlook 2020 оны судалгааны тайлангаас улс орнуудын мэдээллийг түүвэрлэж, боловсруулан харьцуулалт хийв. https://www.swissre.com/dam/jcr:4a1688f7-13e9-4b79-b5ba-917a00d2ea30/sigma4_2020_extra_Complete.pdf холбоосоор харна уу.

дахин бага байгаа нь Монголын даатгалын зах зээл хэр зэрэг нөөц бололцоотой буюу цаашид өсөх боломжтой болохыг харуулж байна.

2. Даатгалын нягтрал буюу нэг хүнд ногдох хураамжийн орлогын харьцааг төгрөгөөр авч үзвэл 2010-2020 оны хооронд 11,506-аас 61,117 хүртэл тогтмол өсөх хандлагатай⁵ байсан хэдий ч ам.долларт шилжүүлэн авч үзвэл 8.5-оос 21.5-ийн хооронд хэлбэлзэж, дунджаар 18.55⁶ байна (тухайн жилийн дундаж ам.долларын ханшийг харгалзах жилийн нягтралд хувааж тооцсон). Энэхүү үзүүлэлт нь 2023 оны жилийн эцсийн байдлаар 113,377.4 төгрөг (33.46 ам.доллар) байгааг хөгжиж буй орнуудын дундаж болох 175 ам.доллартай харьцуулахад 5.2 дахин бага байна⁷.

Иймд даатгалын салбарын хөгжилд тулгамдаад буй асуудлуудыг бодлогын түвшинд шийдвэрлэхдээ олон улсын практикт ашигладаг дээрх 2 гол үзүүлэлтүүдийг нэмэгдүүлэх чиглэлд тулгуурлах нь зүйтэй байна.

- I. **Даатгалын гүнзгийрэлтийн түвшинг** тодорхой үе шаттай нэмэгдүүлэхэд дотоодын даатгагч болон давхар даатгагчдын оролцоог нэмэгдүүлэх, урт хугацааны буюу амьдралын даатгал, заавал даатгуулахаар холбогдох хууль тогтоомжид тусгагдсан даатгалын хамрах хүрээ, хэрэгжилтийг нэмэгдүүлэх, тэдгээрийг бодлогын хүрээнд дэмжих шаардлагатай байна.

Үүнд:

1. Монгол Улсад 2019-2023 онд буюу сүүлийн 5 жилийн хугацаанд даатгалын компаниуд нийт хураамжийн орлогын 29.8 хувь буюу нийт 403.1 тэрбум төгрөгийг олон улсын давхар даатгалын хураамжид зарцуулан эргүүлэн нөхөн төлбөрт дунджаар 47.6 тэрбум төгрөгийг авсан үзүүлэлттэй байх бөгөөд дээрх валютын гадагшлах урсгалыг дотоодын зах зээлд шингээх бололцоог хууль, эрх зүйн бодлогын түвшинд тусгах шаардлагатай байна⁸.

2. Даатгалын үнэлгээ өндөртэй даатгалын гэрээний хувьд дотоодын даатгагч компаниуд өөрийн хөрөнгө, эрсдэл даах чадвараасаа хамаарч даатгалын эрсдэлийн багахан хувийг даатгаад, дийлэнх хувийг гадаадын давхар даатгалд эрсдэлийг шилжүүлж байна. Иймд даатгагчдыг хамтран ажиллах таатай эрх зүйн орчныг бий болгох, хамтын ажиллагааг дэмжихэд чиглэсэн “хамтын даатгал”-ын зохицуулалтыг хуульд тусгаж өгснөөр дотооддоо даатгалын хураамжийн хэмжээг өсгөх боломж бүрдэнэ.

3. Тусгай зөвшөөрөлтэй дотоодын даатгагч компаниуд даатгалын гэрээний тодорхой хувийг гадаадын давхар даатгалын компанид шилжүүлэхээс өмнө

⁵ Санхүүгийн зохицуулах хороо, Даатгалын салбарын 2010-2020 оны 4-р улирлын үйл ажиллагааны нэгдсэн танилцуулгуудаас шаардлагатай тоон мэдээллүүдийг түүвэрлэж, боловсруулав. <http://frc.mn/data/tailan?c=310> холбоосоор харна уу.

⁶ Статистик мэдээллийн сангийн цахим хуудаснаас жилийн дундаж ам.долларын ханшийг авч тооцоолсон. <https://metadata.1212.mn/indicatordata.aspx?id=D9Aq3rXR0cWhlm6LKxRrl49T6O8XYv1wzRl3IfMc/Y=&ln=M> холбоосоор харна уу.

⁷ World insurance: Regional review 2019, and outlook 2020 оны судалгааны тайлангаас улс орнуудын мэдээллийг түүвэрлэж, боловсруулан харьцуулалт хийв. https://www.swissre.com/dam/jcr:4a1688f7-13e9-4b79-b5ba-917a00d2ea30/sigma4_2020_extra_Complete.pdf холбоосоор харна уу.

⁸ Санхүүгийн зохицуулах хороо, Даатгалын салбарын 2018-2023 оны үйл ажиллагааны нэгдсэн танилцуулгуудаас шаардлагатай тоон мэдээллүүдийг түүвэрлэж, боловсруулав. <http://frc.mn/data/tailan?c=310> холбоосоор харна уу.

дотоодын давхар даатгалын компанид гэрээний тодорхой хувийн эрсдэл (тухайн давхар даатгалын эрсдэл даах чадвараас хамаарах)-ийг заавал даатгуулах байдлаар дотоодын зах зээлээ өргөжүүлэх боломжтой.

4. Монгол Улсад мөрдөгдөж байгаа 20 гаруй хууль, тогтоомжид мэргэжлийн үйл ажиллагаа явуулж, олон нийтийн өмнө хариуцлага хүлээж буй этгээдийн хэрэглэгч, ажилтны эрх ашгийг хамгаалах зорилго бүхий заавал даатгалын 26 хэлбэр тусгагдсан байдаг ч тэдгээрийн хэрэгжилт, хяналт орхигдоод байна. Тухайлбал, эдгээр хууль тогтоомжууд дахь заавал даатгалын хэлбэрүүдийн хэрэгжилтийг үнэлэх үүднээс даатгалын компаниудаас (11 даатгалын компани хариулт ирүүлсэн) асуулгын хуудсаар судалгаа авсан ба дараах заавал даатгалуудын хэрэгжилтийг үнэлнэ үү гэсэн 1-р асуултанд хариулсан байдлын нийлбэр дүнг авч үзвэл 54% нь хэрэгжилт хангалтгүй⁹, 46 хувь нь хэрэгжилт сайн¹⁰ гэж үнэлсэн.¹¹ Иймд Даатгалын тухай хууль болон холбогдох хуулиудад шаардлагатай өөрчлөлтийг тусгаж, хэрэгжилтийг сайжруулах практик хэрэгцээ, шаардлага үүсээд байна.

II. **Даатгалын нягтралын түвшнийг** тодорхой үе шаттай нэмэгдүүлэхэд даатгалын хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгтэй бөгөөд үүний тулд нэг талаас даатгуулагчид (олон нийт)-ын даатгалд итгэх итгэлийг нэмэгдүүлж, даатгалын талаарх мэдлэгийг нь сайжруулах, эрх ашгийг нь хамгаалах явдлыг илүү баталгаажуулах, эдгээрийг бодлогын хүрээнд дэмжих шаардлагатай байна.

Олон улсын судалгаагаар хөгжиж буй орнуудад даатгалын салбарын хөгжил хангалтгүй байгаа нь нэг талаас иргэдийн дунд даатгалд итгэх итгэл, даатгуулах сонирхол, ойлголт хангалтгүй, нөгөө талаас даатгуулагчийн эрэлт хэрэгцээнд суурилсан даатгалын бүтээгдэхүүнийг даатгагчид мэргэжлийн түвшинд санал болгохгүй байгаатай холбоотой байна гэж дүгнэсэн байдаг.^{12 13}

Санхүүгийн зохицуулах хорооны захиалгаар Эн-Ар-Си-Си судалгааны агентлагаас санхүүгийн зах зээлийн талаарх хэрэглэгчийн итгэлийг үнэлэх, иргэдийн санхүүгийн зах зээлийн оролцоог судлах зорилгоор улсын хэмжээнд 1000 гаруй иргэдийг хамруулан, санамсаргүй түүврийн аргаар хийсэн **“Санхүүгийн зах зээлийн талаарх хэрэглэгчийн итгэлийн судалгаа”**¹⁴-ны үр дүнгээс харвал иргэдийн 20 гаруй хувь нь сайн дурын даатгалд хамрагддаг байна. Мөн сайн дурын даатгалд хамрагдаагүй шалтгааныг нь тодруулахад:

- Хэрэгцээ шаардлага байхгүй гэдэг шалтгаан хамгийн өндөр буюу дунджаар 34 хувь¹⁵,

⁹ Хэрэгжилт хангалтгүй гэдэгт 1=маш муу, 2=муу, N/A хариулт өгөх боломжгүй буюу тухайн даатгалыг огт хийж байгаагүй гэсэн үнэлгээнүүдийг хамруулав.

¹⁰ Хэрэгжилт сайн гэдэгт 3=дунд зэрэг, 4=сайн, 5=маш сайн гэсэн үнэлгээнүүдийг хамруулав.

¹¹ Ажлын хэсэг, 2018

¹² Global insurance trend analysis, Ernst & Young, 2016

¹³ “Assessment on how strengthening the insurance industry in developing countries contribute to economic growth”, 2006, USAID

¹⁴ “Санхүүгийн зах зээлийн талаарх хэрэглэгчийн итгэлийн судалгаа”, Б.Соёлмаа, Эн-Ар-Си-Си судалгааны агентлаг, 2019

¹⁵ Хэрэгцээ шаардлага байхгүй гэдэг нь нэг талаас даатгалын хэрэгцээ шаардлагаа үнэлж мэддэггүйтэй холбоотой байж болно.

- Даатгалын талаар мэддэггүй гэсэн хариулт дараагийн шалтгаан буюу 26.5 хувь,
- Даатгалын хураамж өндөр гэж 15.9 хувь нь тус тус үзсэн байна.

Түүнчлэн тус судалгаагаар иргэдийн санхүүгийн байгууллагуудад итгэх итгэлийг авч үзэхэд арилжааны банкинд итгэх итгэл хамгийн өндөр буюу 80 гаруй хувь, дараа нь даатгал бөгөөд иргэдийн 50 гаруй хувь нь итгэдэг гэж хариулсан байна.

Цаашилбал, Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлын тоон мэдээг сүүлийн 5 (2019-2023) жилийн байдлаар авч үзвэл нийт өргөдөл, гомдлын 50 орчим хувь нь даатгалын салбарт хамааралтай байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 51.7 хувийг эзэлж байна. Даатгуулагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлын дийлэнх нь даатгалын нөхөн төлбөртэй холбоотой байсан бөгөөд дээрх өргөдөл, гомдлуудыг судлахад даатгалын компаниудын нөхөн төлбөр олгохоос үндэслэлтэй татгалзсан тохиолдол 2019 онд 68.3 хувь, 2020 онд 47.2 хувь, 2021 онд 66.2 хувь, 2022 онд 61.0, 2023 онд 47.2 хувь байсан байна.¹⁶ Өөрөөр хэлбэл, үндэслэлтэй татгалзсан тохиолдлын хувь өндөр байгаа нь нэг талаас даатгуулагчдын даатгалын талаарх мэдлэг тааруу, даатгалын гэрээний талаарх мэдээллийг хангалттай авч чадахгүй байгаатай холбоотой бол нөгөө талаас даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах зайлшгүй шаардлага байгааг харуулж байна.

Иймд манай улсын хувьд иргэдийн санхүүгийн боловсрол, даатгалд итгэх итгэл, даатгуулах сонирхол, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд даатгагчийн үйл ажиллагаанд хязгаарлалт, үүргийг нэмж тусгах шаардлага үүсээд байна.

Үүнд:

1. Даатгагч нар даатгалын гэрээ, бүтээгдэхүүнтэй холбогдох бүхий л мэдээллийг даатгуулагчид өгөх нь даатгуулагчийн даатгалын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, даатгалын тохиолдол болж, даатгуулагч нөхөн төлбөр авахад үл ойлголцол бий болохоос сэргийлэх ач холбогдолтой.
2. Даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлд даатгалын нөхөн төлбөр нэхэмжлэхэд шаардагдах баримт бичгүүдийг хуульчилсан байдаг бөгөөд түүнд даатгалын баталгааны эх хувийг шаардсан байдаг. Техник технологийн хөгжил, даатгагч нарын цахим мэдээллийн сан бүрдүүлэлт зэрэгтэй холбоотойгоор нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах үед даатгалын баталгааг эх хувиар бүрдүүлэх шаардлагагүй болсон бөгөөд өөрөөр хэлбэл даатгагч нь даатгуулагчийн гэрээ, баталгааг даатгуулагчийн зохих биеийн байцаалт эсвэл холбогдох баримт бичгийг ашиглан өөрсдөө шүүж шалгах боломж нөхцөл бүрдсэн болно.¹⁷ Нөгөө талаас даатгуулагч нь даатгалын тохиолдлын улмаас даатгалын баталгааг үрэгдүүлсэн нөхцөлд зайлшгүй дахин гаргуулах шаардлага үүсч байгаа нь даатгуулагчид хүндрэлтэй байдлыг бий болгохоос гадна баталгааг эх хувиар шаардах нь нөхөн төлбөр нэхэмжлэгчид тодорхой цаг хугацаа шаардсан, үр ашиггүй үйл ажиллагаа болоод байна. Иймд

¹⁶ Санхүүгийн зохицуулах хороо, Өргөдөл гомдлын судалгаа 2019, 2020, 2021, 2022, 2023-аас түүвэрлэж, боловсруулав.

¹⁷ Монголын даатгалын холбоо, 2018

даатгуулагчаас нөхөн төлбөр нэхэмжлэх, өргөдөл гаргах үйл явцыг илүү хялбаршуулах, нөхөн төлбөр нэхэмжлэхтэй холбоотой баримт материалыг эх хувиар болон бичгээр шаардаж байгаа зарим зүйл заалтыг эргэн харах практик шаардлага үүсч байна.

3. Хорооны 2020.10.07-ны өдрийн 936 дугаар тогтоолоор өгсөн үүрэг даалгавар, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага хангагдаагүй буюу төлбөрийн чадваргүй болсон тул “Соёмбо даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. Үүнтэй холбогдуулан зөвхөн шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолын хүрээнд авч үзэхэд иргэд, даатгуулагчид (1 байгууллага, 5 иргэн) нийт 120,760,316.00 төгрөгийн нөхөн төлбөрийг тус компаниар гаргуулж чадахгүй, хохироод байгаа юм. Харин 2019-2021 оны хооронд Хороонд “Соёмбо даатгал” ХХК-тай холбогдох 43 өргөдөл гомдол ирүүлсэн бөгөөд нийт 40 иргэн байгууллагын 297.3 сая төгрөгийн хохирлыг тус компани барагдуулаагүй байдалтай байна. Мөн олон улсын сайн туршлагыг авч үзвэл, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын гишүүн 26 оронд (2013 оны байдлаар) даатгагч төлбөрийн чадваргүй болох, дампуурах, түүний улмаас даатгуулагч хохирох эрсдэлээс хамгаалах, салбарын тогтвортой байдлыг хангах зорилго бүхий даатгалын салбарын эрсдэлийг бүхэлд нь (нэгдсэн схем - Солонгос, Испани, Их Британи, хэд хэдэн схемийн хүрээнд Канад, Франц, Япон, АНУ), хэсэгчлэн (зөвхөн амьдралын бус даатгал – Австрали, Дани, Норвег, зөвхөн амьдралын даатгал – Австри, Герман, Грек,) эсхүл жолоочийн хариуцлагын даатгал, ажилчдын гэнэтийн осол, гуравдагч этгээдийн хариуцлага, хувийн эрүүл мэндийн даатгал зэрэг нэр бүхий даатгалын эрсдэлийг хамарсан Даатгуулагчийн хамгаалалтын схем (Policyholder Protection Scheme) байдаг байна. Иймд даатгагч дампуурах, түүний улмаас даатгуулагч хохирох эрсдэлээс хамгаалах, салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор дотоодын практик хэрэгцээ, шаардлага, олон улсын сайн туршлагад үндэслэн даатгалын баталгаат сангийн талаарх зохицуулалтыг бий болгосноор олон нийтийн даатгалд итгэх итгэл нэмэгдэх, салбарын нэр хүнд өсөх зэрэг эерэг нөлөөллийг бий болгоно.
4. Түүнчлэн техник, технологийн хөгжлийг дагаад хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага өөрчлөгдөж, бүтээгдэхүүн үйлчилгээг цаг хугацаа хэмнэсэн, илүү хялбар буюу цахим байдлаар авах хэрэгцээ үүссэн. Энэхүү хэрэгцээг дагаад даатгалын компаниуд цахим хэлбэрээр даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээгээ аль хэдийнээ санал болгоод эхэлсэн байгаа боловч үүнтэй холбоотой зохицуулалт нь хоцроод байна. Жишээлбэл, Тэнгэр даатгал ХХК 6 даатгалын бүтээгдэхүүн, Бодь даатгал ХК 8 даатгалын бүтээгдэхүүн, Номин даатгал ХХК 5 даатгалын бүтээгдэхүүн, онлайн даатгалууд, мобайл аппликэйшн болон чатбот хэрэглээнд нэвтрүүлээд байгаа билээ¹⁸. Иймд даатгалын үйл ажиллагаанд цахим хэлбэрийг ашиглахтай холбогдоотой зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

¹⁸ Эдгээр даатгалын компаниудын цахим хуудаснуудаас түүвэрлэж, бэлтгэв.

5. Даатгагч нар нь даатгалын үйл ажиллагаа эрхлэхдээ даатгуулагчид мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр урамшуулал олгох, чанаргүй гэрээ байгуулах зэрэг сөрөг үзэгдлүүд бий болж байгаа нь даатгалын үйл ажиллагаанд оролцогчдын өрсөлдөөнийг хязгаарласан, даатгуулагчийн эрх ашгийг хөндсөн зэрэг нөхцөл байдлыг үүсгэж байна. Тухайлбал, заавал даатгуулахаар заасан бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх үүднээс жишээ болгон Үндэсний баяр наадмын тухай хууль дахь заавал даатгалын талаар даатгагчдаас авсан асуулга судалгааны тулгарч буй саад бэрхшээлүүдийн талаархи асуултанд 11 даатгалын компаниас 3 компани "... даатгалын компаниудын тэгш оролцоог хангах..." гэж тус тус хариулсан байна. Энэ нь нэг талаас даатгагчдын шударга өрсөлдөөнийг хангах, тэгш боломжийг бүрдүүлэх, ингэснээр нөгөө талаас даатгуулагчдад сонголтыг олгох буюу тэдний эрх ашгийг хамгаалах тодорхой шаардлага байгааг харуулна. Иймд даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд даатгагчийн үйл ажиллагаанд зарим хязгаарлалт, үүргийг нэмж тусгаад, даатгуулагч даатгалын компаниа чөлөөтэй сонгох эрхийг тодорхой тусгах замаар баталгаажуулах шаардлагатай байна.
6. Олон улсад даатгуулагчийн төлсөн хураамж, хөрөнгийг зөв зохистой удирдах, хууль бус үйлдлийг бууруулах зорилгоор даатгалын компаниудын засаглалыг сайжруулахад анхаарал хандуулах болсон. Тухайлбал, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага нь "Даатгагчийн засаглалын талаарх ЭЗХАХБ-ын удирдамж"¹⁹, "Олон улсын даатгалын зохицуулагч байгууллагуудын холбоо"²⁰ нь даатгалын мониторингийн зарчмууд²¹, корпорацийн (даатгалын компани) засаглалын хандлагууд²² гэх зэрэг баримт бичгүүдийг гарган гишүүн орнууд, байгууллагууддаа санал болгож, мөрдүүлэн ажиллаж байна. Даатгалын компанийн засаглалын тогтолцоог сайжруулах нь даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахад дэмжлэг үзүүлдэг тул зарим хязгаарлалт, өөрчлөлтүүдийг хуульд тусгах хэрэгцээ шаардлага үүсээд байна.
7. Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх, даатгалын хохирол үнэлэх үйл явцыг хөнгөвчлөх, даатгуулагчийн хохирол үнэлгээний зардлын ачааллыг бууруулах зорилгоор даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулах нь даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах болон даатгалын салбарын нэр хүндийг өсгөх ач холбогдолтой юм.

¹⁹ OECD Guidelines on Insurer Governance, OECD, Edition 2017, <https://www.oecd.org/daf/fin/insurance/48071279.pdf> холбоосоор харна уу.

²⁰ IAIS – International Association of Insurance Supervisors

²¹ Corporate Governance in Insurance Companies, Vladimir Njegomir, Fakultet Za Pravne I Poslovne Studije Dr Lazar Vrkatic, 2014,

https://www.researchgate.net/publication/312214674_Corporate_Governance_in_Insurance_Companies/link/5876e6c108ae329d62260fdd/download холбоосоор харна уу.

²² Approaches to Group Corporate Governance; Impact Control Functions, 2014,

<https://www.iaisweb.org/file/34545/issues-paper-on-approaches-to-group-corporate-governance> холбоосоор харна уу. IAIS – International Association of Insurance Supervisors (Санхүүгийн зохицуулах хороо нь энэхүү ОУ-ын байгууллагын гишүүн болно.)

Олон улсын практикт зарим төрлийн даатгалын харилцаанд хохирол үнэлэгчийн оролцоо заавал шаардлагагүй байдаг. Жишээлбэл: Даатгалын зах зээл нь хурдацтай хөгжиж буй БНХАУ, Даатгалын зах зээлийн хөгжлийн 2 гол үзүүлэлтээр манай улстай ойролцоо Украин улс болон Камбож улсуудын Даатгалын тухай хуулиудыг судалж үзэхэд:

- *Даатгалын тухай хууль, 1995: 22 дугаар зүйл.* Даатгуулагч даатгалын тохиолдлыг даатгагчид мэдэгдэж, хохирлыг тогтооход шаардлагатай боломжит бүх мэдээллийг өгнө.²³
- *Даатгалын тухай хууль, 1996: 24 дүгээр зүйл.* Даатгалын нөхөн төлбөрийг даатгуулагчийн нэхэмжлэл болон даатгагчийн эсвэл даатгуулагчийн итгэмжилсэн хохирол үнэлэгчийн үнэлгээн дээр үндэслэн олгоно.²⁴
- *Даатгалын тухай хууль, 2000:* Тодорхой тусгаагүй байна (Энэ нь нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргахдаа даатгагчид шууд хандана гэж ойлгогдож байна).²⁵

гэж тус тус заасан байна.

Нөхөн төлбөр нэхэмжлэх үйл явц дахь хохирол үнэлэгчийн оролцоог гэрээнд тусгасан эсвэл шаардлагатай тохиолдолд болгож өөрчилснөөр энэхүү үйл явцыг илүү хялбарчлах буюу үр ашигтай болгох боломжтой болох юм.

8. Олон улсад даатгалыг амьдралын болон амьдралын бус гэж ангилан үздэг. Амьдралын даатгал нь даатгуулагчийн амь нас, хөдөлмөрийн чадвараа алдах, зарим төрлийн өвчин эмгэг болон урт наслалттай холбоотой удаан хугацаанд үүсч болох хувь хүний санхүүгийн эрсдэлүүдийг даатгах үйл ажиллагаа явуулдаг. Манай улсын хувьд ердийн болон урт хугацааны даатгалын ангиллын зааг ялгааг хуулиар тодорхой заагаагүйгээс урт хугацаанд хийгдэх зарим даатгалын хэлбэрийг ердийн даатгалын компаниуд эрхэлж байгаа нь нэг талаас урт хугацааны даатгалын үйл ажиллагааны өсөлтийг хязгаарлах, нөгөө талаас даатгуулагчдад буруу ойлголт төрүүлэх эрсдэлийг дагуулж байна. 2016-2020 оны хооронд анхан шатны шүүхийн 50 шийдвэрийг судалж үзэхэд 9 нь ипотекийн зээлийн даатгалтай холбоотой маргаан байв. Ипотекийн зээлийн гэрээ нь 10-аас дээш жилээр хийгдэж байгаа боловч урт хугацаанд хувь хүнд үүсэх өвчин эмгэг зэргийг гэнэтийн ослын даатгалын тохиолдолд тооцдоггүй нь даатгагч, даатгуулагчийн хооронд үүсч буй маргааны нэг шалтгаан болж байна. Тухайлбал, Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо мэдээг сүүлийн 5 (2018-2022) жилийн байдлаар авч үзвэл даатгалын салбарт хамааралтай нийт өргөдөл, гомдолд орон сууцны зээлдэгчийн эрсдэлийн даатгалтай холбоотой өргөдөл, гомдлууд нь 3-т буюу жолоочийн

²³ Insurance Law of the People's Republic of China, 1995,
http://www.fdi.gov.cn/1800000121_39_3063_0_7.html холбоосоор харна уу.

²⁴ Law of Ukraine on Insurance, 1996,
https://www.wto.org/english/thewto_e/acc_e/ukr_e/WTACCUKR26_LEG_13.pdf холбоосоор харна уу.

²⁵ Insurance Law of the Kingdom of Cambodia, 2000,
<https://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/86080/96913/F580020967/KHM86080.pdf> холбоосоор харна уу.

хариуцлагын даатгал болон тээврийн хэрэгслийн даатгалын дараа орж байна.²⁶ Иймд урт хугацаанд даатгуулах нь тодорхой эсвэл хууль, журмаар шаардсан бөгөөд хүний амь нас, орлоготой холбоотой эрсдэлийг тус ангилалд оруулах нь даатгуулагчийн эрх ашигт нийцэх тул ангиллын нэршлийг иргэдэд илүү ойлгомжтойгоор буюу амьдралын болон ердийн (амьдралын бус) гэж томъёолох хэрэгцээ үүсч байна. Түүнчлэн энэ нь амьдралын даатгалын үйл ажиллагааг шууд бус хэлбэрээр дэмжинэ.

Мөн даатгалын салбарт оролцогч бусад мэргэжлийн оролцогчдын хувьд:

9. Даатгагч нь даатгалын гэрээ зуучлан борлуулсны төлөө зөвхөн тусгай зөвшөөрөл бүхий даатгалын төлөөлөгч, зуучлагчид даатгалын хураамжийн шимтгэл олгох ёстой байтал, тусгай зөвшөөрөлгүй этгээдэд аливаа төлбөр төлж байгаа тохиолдлууд практик дээр байгаа нь даатгалын мэргэжлийн оролцогчдын шударга өрсөлдөөнийг хязгаарласан, даатгуулагчийн эрх ашгийг зөрчсөн зэрэг нөхцөл байдлыг бий болгож байна. Иймд даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд даатгагч, даатгалын төлөөлөгч, зуучлагчийн үйл ажиллагаанд зарим хэм хэмжээ, үүргийг нэмж тусгах шаардлагатай байна.
10. Даатгалын тухай хуулийн 12¹ дүгээр зүйлийн хүрээнд албан журмын даатгалын үйл ажиллагаа явуулж буй даатгагчид нь Албан журмын даатгагчдын холбоонд гишүүнчлэлтэй байхыг үүрэг болгосон байдаг. Тус холбоо нь мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, даатгалын тохиолдлын үнэн зөвийг тодорхойлох үүрэг бүхий шуурхай алба болон албан журмын даатгалын санг удирдах үүрэгтэй байхаар заасан. Гэвч тус холбооны статус нь төрийн эсвэл төрийн бус эсэх нь тодорхойгүй байгаа ба байгуулагдсанаас хойш зөвхөн жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын холбоо хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулахын зэрэгцээ холбоонд нэгдсэн даатгагчидтай хэрхэн хамтарч ажиллах, салбарын хөгжилд оруулах хувь нэмэр, оролцоо, үйл ажиллагааг тодорхой зааж хуульчлаагүй. Цаашилбал, ОУ-ын туршлагаас харвал автотээврийн хэрэгслийн гуравдагч этгээдийн хариуцлагын албан журмын даатгалын хувьд энэ даатгалд тусгайлан зориулсан “Баталгааны сан”-тай байдаг байна²⁷. Тодруулбал, 1978 онд Даатгалын эрх зүйн олон улсын холбооны²⁸ хүрээнд үүсгэн байгуулагдсан Авто тээврийн хэрэгслийн даатгалын ажлын хэсгийн²⁹ “Дэлхийн авто тээврийн хэрэгслийн гуравдагч этгээдийн хариуцлагын даатгалын норматив, удирдлагын шинж чанарууд” тайланд дурьдсан дэлхийн 194 орноос 165 нь авто тээврийн хэрэгслийн гуравдагч этгээдийн хариуцлагын албан журмын даатгалтай бөгөөд ихэнх орнуудад зам тээврийн ослын хохирогчдод зориулсан Баталгааны сан эсвэл үүнтэй төстэй

²⁶ Санхүүгийн зохицуулах хороо, Өргөдөл гомдлын судалгаа, 2018, 2019, 2020.

²⁷ Motor Third-Party Liability Insurance, Serap Gonulal, Primer series on insurance issue 16, 2010, Non-Bank Financial Institutions Group, The World Bank, http://siteresources.worldbank.org/EXTFINANCIALSECTOR/Resources/282884-1242281415644/Motor_3rd_party_liability_insurance.pdf холбоосоор харна уу.

²⁸ International Association of Insurance Law - Даатгалын эрхзүйн олон улсын холбоо

²⁹ The Motor Insurance Working Group - Авто тээврийн хэрэгслийн даатгалын ажлын хэсэг

тогтолцоотой байсан³⁰. Иймд Даатгалын тухай хуулийн 12¹ дүгээр зүйлд заасан Албан журмын даатгагчдын холбооны үйл ажиллагааг төрөлжүүлж, нарийвчлан зохицуулах нь илүү зохимжтой байна.

Салбарын хэмжээнд мэргэжлийн байгууллагын зохицуулалтыг тусгах шаардлагатай эсэх тал дээр олон улсын болон дотоодын туршлагаас судалж үзэхэд салбарын мэргэжлийн холбоодыг холбогдох хууль, журамд тусгаж өгөх замаар мэргэжлийн байгууллага болгон хөгжүүлэх нь салбарын хөгжлийг дэмжих, мөн бусад зохицуулалтын үйл ажиллагааг шилжүүлэх замаар салбарын оролцогчдын эрх ашгийг хамгаалах зэрэг олон давуу талыг бий болгох юм.

Монгол Улсад болон олон улсын хэмжээнд мэргэжлийн байгууллагын чиг үүргийг тухайн салбарын хууль тогтоомжид тусгайлан тусган, эрх үүрэг, ажиллах хүрээг тодорхойлж өгдөг. Даатгалын салбарын хэмжээнд хэрэгжүүлэх төрийн зохицуулалтыг мэргэжлийн байгууллагад шилжүүлэх нь даатгуулагч, даатгагч, мэргэжлийн оролцогчид, төрийн зохицуулагч болон салбарт олон давуу талыг олгохоор байна.

- Мэргэшсэн байдал. Мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг салбарын мэргэшсэн боловсон хүчин удирдан явуулснаар нь практикт тулгараад буй олон асуудлыг шийдвэрлэх боломжийг олгоно. Мөн салбарын үйл ажиллагааг тогтвортой чиглүүлэн ажиллах чиг үүргийг оролцогчдод шууд олгож, илүү хариуцлагатай санаачилгатай ажиллах шаардлагыг бий болгож байна.
- Ёс зүйн стандарт. Салбарын оролцогчдоос бүрдсэн нэгдсэн биеэ даасан бүтэц бий болгосноор тухайн салбарын ёс зүйн стандартыг практикт тулгуурлан шинэчлэн тогтоож, өөрийн хяналт зохицуулалтыг нэвтрүүлснээр хөрөнгө оруулагч, даатгуулагчдын салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.
- Хяналт. Мэргэжлийн байгууллага нь төрийн зохицуулалтын байгууллага шиг улсын төсвийн хараат байдалд үйл ажиллагаа явуулахгүй зөвхөн дотоодын санхүүжилтээр үйл ажиллагаа явуулах тул дотооддоо авч хэрэгжүүлэх хяналтын тогтолцоо илүү үр өгөөжтэй болж, байнгын хяналтад шилжих боломж нээгдэнэ.
- Бодлого боловсруулах. Мэргэжлийн байгууллагад хууль тогтоомжид заасан тодорхой эрх үүргийг олгосноор салбарын оролцогчид бодлого боловсруулагчдын хамтын ажиллагаа нэмэгдэж, илүү үр дүнтэй байдлаар салбарын хөгжлийн бодлогын боловсруулж, удирдан чиглүүлэх боломж нэмэгдэнэ.
- Уялдаатай үйл ажиллагаа. Төрийн зохицуулагч байгууллагын зохицуулалтын хэт төвлөрлийг сааруулж, салбарын мэргэжлийн оролцогчдод өөрсдийн хөгжлийн тодорхойлох эрх үүргийг олгох замаар хамтын ажиллагааны уялдааг дээшлүүлнэ.

Иймд аргачлалын 3-т заасны дагуу дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж,

³⁰ Normative and Management Characteristics of Motor Third Party Liability Insurance in the World, Motor Insurance Working Group, 2010, <http://www.aida.org.uk/pdf/MIWP%20Report.pdf> холбоосоор харна уу.

асуудлыг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

Дээр дурдсан нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд дараах асуудлууд голлож байна. Үүнд:

- Дотоодын давхар даатгагчдыг дэмжих, тэдгээрийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, тулгарч буй эрсдэлийг бууруулах, валютын гадагшлах урсгалыг багасгах зорилгоор дотоодын давхар даатгагчийг чадавхжуулах, давхар даатгалын үйл ажиллагааг дэмжсэн зохицуулалтыг бий болгох.
- Даатгалын үнэлгээ өндөртэй даатгалын гэрээг дотоодын даатгагчид дангаар хийх боломжгүй нөхцөлд гадаадын даатгагчаар даатгуулах тохиолдлууд гарч байна. Иймд даатгагчдыг хамтран ажиллах буюу хамтын даатгалыг нэвтрүүлэх хүрээнд холбогдох эрх зүйн орчныг бий болгож, хамтын ажиллагааг дэмжихээс гадна даатгагч нь даатгалын эрсдэлийг шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн арга хэрэгслийг ашиглан даатгалын эрсдэлийг хөрөнгийн зах зээлд гаргаж болох боломжийг бүрдүүлэх.
- Даатгагч дампуурах, түүний улмаас даатгуулагч хохирох эрсдэлээс хамгаалах, салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор практик хэрэгцээ, шаардлага, олон улсын сайн туршлагад үндэслэн заавал даатгалын баталгаат сангийн талаарх зохицуулалтыг бий болгох.
- Хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр эрсдэлд суурилсан хяналт шалгалт, цахим хяналт шалгалт, нэгдсэн хяналт шалгалттай холбоотой зохицуулалтыг нэмж тусгах.
- Даатгуулагчийн нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах үйл явц болон хуулийн дагуу бүрдүүлэх шаардлагатай баримт бичиг нь цаг үеийн хөгжлөөс хоцрогдсон, бүх төрлийн даатгалын төрөлд тохирохгүй байгаа ба зарим нэг талаар иргэдэд хүндрэл учруулж байна. Иймд орчин үеийн хөгжил дэвшилтэй нийцүүлэн сайжруулах, цаашилбал цахим хэлбэрт шилжүүлэх боломжийг бүрдүүлэх.
- Даатгалын салбарт оролцогчид технологийн дэвшилд (*иншуртек*) суурилсан даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлж, даатгуулагчид болон оролцогчдын үйл ажиллагааг хөнгөвчилж ажиллах хандлагатай байна. Иймд даатгалын үйл ажиллагаанд цахим болон дэвшилтэт технологийг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх.
- Олон улсад даатгалын хохирол үнэлэгч этгээд нь ихэвчлэн даатгалын компанийн ажилтан, хувь хүн эсхүл хөндлөнгийн даатгалын хохирол үнэлэгч мэргэшсэн этгээд байж тухайн улсынхаа Даатгалын тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг байна. Иймд холбогдох өөрчлөлтийг оруулах замаар нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах, хохирол үнэлгээ хийх, нөхөн төлбөр олгох үйл явцыг хялбарчлах, даатгуулагчид учирах хохирол үнэлгээний зардлыг хэмнэх, хохирол үнэлгээг улам боловсронгуй болгож, олон улсын жишигт нийцүүлэх.
- Олон улсад даатгуулагчийн төлсөн хураамж, хөрөнгийг зөв зохистой удирдах, хууль бус үйлдлийг бууруулах зорилгоор даатгалын компаниудын засаглал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулахад

анхаарал хандуулах болсон. Даатгалын компанийн засаглалын тогтолцоо, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах нь даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахад дэмжлэг үзүүлдэг тул зарим хязгаарлалт, өөрчлөлтүүдийг хуульд тусгах.

- Ердийн болон урт хугацааны даатгалын зааг ялгааг хуулиар тодорхой заагаагүйгээс урт хугацаанд хийгдэх шаардлагатай зарим нэг даатгалыг ердийн даатгалын хэлбэрт шилжүүлэн хийсний улмаас даатгуулагч хохирох асуудал гарч байна. Иймд урт хугацааны болон ердийн даатгалын зааг ялгааг тодорхой болгох, олон улсын нэршилтэй нийцүүлэх.
- Даатгалын тухай хуульд тусгагдсан Албан журмын даатгагчдын холбоо нь бүх төрлийн албан журмын даатгалын төрөлд хамаарах шаардлагагүй, мөн статус нь тодорхойгүй байгаа тул холбогдох зүйл, заалтад нэмэлт өөрчлөлт оруулж, нарийвчлан зохицуулах.
- Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаарх зохицуулалтыг илүү төрөлжсөн буюу Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна.

1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох:

Дээр тодорхойлсон цар хүрээтэй холбоотойгоор дараах нийгмийн бүлэг, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна гэж үзлээ.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
Даатгагч	Даатгагчдын эрсдэлийн удирдлага, компанийн засаглалд тавих шаардлагуудыг олон улсын туршлагад нийцүүлэн хуульд тусгах замаар даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг сайжруулах, даатгалын салбарт эрсдэлийн удирдлагын оновчтой тогтолцоо бүрдэх боломжийг нэмэгдүүлнэ. Дотоодын давхар даатгалын тогтолцоог хуулиар дэмжсэнээр дотоодын даатгагч нарын чадавх нэмэгдэх, даатгалын зах зээл өргөжин тэлэх болно.
Даатгуулагч	Даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд даатгуулагчид даатгалын гэрээний талаар анхан шатны эрх үүргийг агуулсан мэдээллийг ойлгомжтой гаргаж өгөх даатгагчийн үүргийг бий болгох, нөхөн төлбөр нэхэмжлэлийн үйл явцыг хялбаршуулна. Мөн хохирол үнэлгээтэй холбоотойгоор даатгуулагчийн нөхөн төлбөр нэхэмжлэх хугацаа, хохирол үнэлгээний зардал буурна.
Гадаадын даатгагч	Бусад улс орнуудын нийтлэг жишгийн дагуу гадаадын даатгагч нарт тавих хяналт, хязгаарлалтыг сайжруулан зарим нэг хяналт тавих боломжгүй буюу гадаад талтай шууд гэрээ байгуулах шаардлагатай даатгалын гэрээг хуулиар тодорхойлно.
Даатгалын хохирол үнэлэгч	Даатгалын хохирол үнэлэгч нь даатгалын мэргэжлийн оролцогчийн статусгүй болох ба бие даасан хэлбэрээр хөгжсөнөөр хохирол үнэлгээчдийн мэдлэг чадварыг

	сайжирна.

1.3. Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох:

Даатгалын тухай хууль нь 2004 онд шинэчлэн батлагдсанаар санхүүгийн зах зээл тухайлбал, даатгалын зах зээлийг зохицуулалттай, хяналттай хөгжиж ирэхэд тодорхой хувь нэмрийг оруулсан.

Гэвч олон улсын даатгалын зах зээлийн хөгжил, дотоодын зах зээлд оролцогчдын нөөц чадавх, орчин үеийн техник технологийн хөгжил дэвшилтэй холбоотойгоор цаашид даатгалын салбарыг олон улсын чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэх, нийгэм, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд даатгалын салбарын эрх зүйн орчныг үе шаттайгаар шинэчлэх зайлшгүй шаардлага үүсээд байна.

Монгол Улс нь зах зээлийн эдийн засагт шилжиж хувийн өмчийн тухай ойлголт бий болсонтой зэрэгцэн өнгөрсөн 28 жилд банкны салбар эрчимтэй хөгжиж ирсэн боловч даатгалын салбарын хөгжил харьцангуй удаашралтай байна. 2011 онд Жолоочийн даатгалын тухай хуулийг баталж, Монгол Улсад жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг хэрэгжүүлж эхэлсэн нь олон нийтийн даатгалын тухай ойлголт, мэдлэгийг сайжруулахад томоохон түлхэц болсон. Гэвч жолоочийн хариуцлагын албан журмын даатгалтай холбоотойгоор даатгалд хамрагдсан иргэдийн тоо өссөн боловч даатгалын салбар тэр хэмжээгээр төдийлөн хөгжиж чадаагүй байна.

Энэ нь нэгдүгээрт, даатгалын ач холбогдлын талаарх иргэдийн мэдлэг, мэдээлэл хангалттай бус, хоёрдугаарт даатгалын компаниудад итгэх иргэдийн итгэл дутмаг, гуравдугаарт даатгалд хамрагдсан хэдий ч түүний ач холбогдлыг сайтар ойлгоогүй, мэдээлэл дутуу байх зэрэг сөрөг үзэгдлүүд иргэдийн дунд түгээмэл байгаатай холбоотой байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Хуулийн төслийг боловсруулах зорилго нь даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах үйл явцыг хялбарчлах, даатгагчдын хамтын ажиллагааг дэмжих, дотоодын давхар даатгалын үйл ажиллагааг дэмжих замаар валютын гадагшлах урсгалыг бууруулах, даатгалын ангиллыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчилж, даатгагчид тавигдах шаардлага, зохицуулалтыг тодорхой болгох, хяналт, зохицуулалтын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомж хоорондын хийдэл, зөрчлийг арилгахад оршино.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН ХАРЬЦУУЛАЛТ

Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, аргачлалын 5-д заасны дагуу судалж үзлээ.

3.1. Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах:

Даатгалын тухай хуулийг шинэчлэхгүй үргэлжлүүлснээр салбарын хөгжил, үйлчилгээний цар хүрээ, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хяналт, зохицуулалтыг сайжруулах нөхцөл бүрдэхгүй байх, олон улсын жишиг, хөгжлийн чиг хандлагад нийцэхгүй байх нөхцөл үүсэх бөгөөд асуудлыг шийдвэрлэхэд үр нөлөө үзүүлэхгүй.

3.2. Хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулга, сурталчилгааны ажил өрнүүлэх хувилбар

Асуудлыг шийдвэрлэхийн тулд одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийг олон нийтэд сурталчлан таниулах ажил өрнүүлэх нь зорилгыг хангах арга зам биш юм. Энэхүү хувилбар нь үйл ажиллагааг бүрэн зохицуулах, хяналт, хариуцлагыг тодорхой болгох боломжийг бүрдүүлэхгүй бөгөөд үүнд хуулийг олон нийтэд сурталчлан таниулахад тодорхой хэмжээний зардал, хөрөнгийг шаардах хэдий ч үүсээд буй нөхцөл байдлын шалтгааныг арилгаж, үр дагаврыг бууруулах боломжгүй юм.

3.3. Зах зээлийн эдийн засгийн хэрэгслийг ашиглан төрөөс зохицуулах хувилбар

Санхүүгийн зохицуулах хороо төрийн зохицуулагч байгууллагын хувьд даатгалын салбарын үйл ажиллагаанд хяналт, зохицуулалтыг хийж, салбарын тогтвортой байдлыг ханган ажиллаж байгаа хэдий ч цаашид хэрэгжүүлэх зохицуулалтын шинэ тогтолцоо, зах зээлийн хөгжлийг дэмжсэн өргөн цар хүрээтэй бодлогыг хэрэгжүүлэх, эрх зүйн таатай орчныг бий болгоход өнөөгийн эрх зүйн орчин хангалтгүй байна. Иймд зах зээлийн эдийн засгийн хэрэгслийг ашиглан дан ганц төрөөс зохицуулах хувилбар нь үр нөлөөгүй бөгөөд энэхүү хувилбар нь зардал, хөрөнгийг хэмнэх боломжтой ч тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж чадахгүй буюу тулгарч байгаа бэрхшээлийг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй гэж дүгнэж байна.

3.4. Төрөөс санхүүгийн интервенц хийх хувилбар:

Энэхүү хувилбарыг ашиглан төрөөс интервенц хийх нь зардал хөрөнгө зарцуулах сөрөг талтайгаас гадна асуудлын шалтгааныг арилган зорьж буй үр дүнд хүрэхгүй бөгөөд сөрөг үр дагаврыг бууруулахгүй. Хуулийн зохицуулалттай холбоотой бүтцийн шинжтэй асуудал учир энэхүү хувилбарыг хэрэгжүүлснээр зорьж буй үр дүнд хүрэх боломжгүй буюу асуудлын шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулахгүй гэж үзлээ.

3.5. Төрийн бус байгууллага, хувийн хэвшилээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх хувилбар:

Одоогийн дагаж мөрдөж буй Даатгалын тухай хуулиар тодорхойлсон чиг үүрэг нь зөвхөн төрийн байгууллагын чиг үүрэгт тусгайлан харьяалуулсан зохицуулалт, хяналтын тогтолцоонд багтдаг бөгөөд даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага болох мэргэжлийн холбооны

үйл ажиллагаагаар дамжуулан асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм.

3.6. Захиргааны шийдвэр гаргах хувилбар:

Даатгалын тухай хуулийн төслийг шинэчлэн найруулахгүйгээр Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлд заасан захиргааны акт, захиргааны гэрээ, захиргааны хэм хэмжээний акт буюу захиргааны шийдвэр гаргах ажиллагаа хийх замаар асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм. Учир нь даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавихад төрийн байгууллагын хувьд зөвхөн хуулиар тусгайлан эрх олгосон тохиолдолд зөвшөөрөгддөг тул захиргааны шийдвэр гаргах замаар зохицуулах боломжгүй гэж дүгнэлээ.

3.7. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар:

Даатгалын салбарын өнөөгийн нөхцөл байдалд хийсэн судалгаа, дүн шинжилгээний үр дүнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зорилтуудыг хангахад зөвхөн хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой тул хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг хамгийн оновчтой, үр дүнтэй хувилбар гэж дүгнэж байна.

3.8. Асуудлыг шийдвэрлэх хувилбаруудын харьцуулалт

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу хуулийн төсөл боловсруулах зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

	Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1.	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа шийдвэрлэх асуудал, бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй	Нэмэлт зардал гарахгүй ч, сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг
2.	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд хууль тогтоомж хоорондын хийдэл, зөрчил арилахгүй.	Ухуулга, сурталчилгаатай холбоотой зардал гарах ба энэ нь олон нийтийн даатгалын талаарх мэдлэгийг зарим талаар нэмэгдүүлэх үр нөлөөг авчирч болох ч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг (ялангуяа	Тодорхой үр дүнд хүрэхгүй.

			тогтолцооны шинж чанартай) арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	
3.	Захиргааны шийдвэр гаргах	Даатгалын үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмыг баталж тодорхой асуудлуудыг шийдвэрлэж болох хэдий ч зарим нэг зорилгыг хуульчлах шаардлагатай. Иргэдийн эрх ашгийг бүрэн хамгаалж чадахгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, зорилгод тусгагдсан үр дүнд хүрэх боломжгүй.	Шаардлагатай үр дүнд хүрэхгүй.
4.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Даатгалын үйл ажиллагаанд тулгамдаад байгаа бэрхшээл, асуудлыг шийдвэрлэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой.	Зардал* гарах боловч энэ нь хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй

* Даатгалын компаниудын хувьд компанийн засаглалтай холбоотойгоор зарим нэг бүтцийн өөрчлөлт хийх, даатгуулагч бүрд даатгалын мэдээлэх хуудас өгөх зардлууд гарах хэдий ч нөгөө талаас системийн түвшинд эрсдэлийн удирдлагын тогтолцоо сайжрах, даатгуулагчдын даатгалын талаарх мэдлэг, даатгалд итгэх итгэл болон даатгуулах сонирхол нэмэгдэх, даатгуулагчдаас ирүүлэх өргөдөл, гомдлын тоо буурснаар даатгагч болон зохицуулах байгууллагуудын үйл ажиллагааны ачаалал, зардал буурах, нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах үйл явц хялбар болсноор даатгагч, даатгуулагчийн хувьд цаг хугацаа, зардал хэмнэх, хамтарсан даатгал, давхар даатгалын үйл ажиллагаагаар дамжин хураамжийн орлого өсөх зэрэг үр өгөөжийг авчирна.

Зорилгод хүрэх байдал, эерэг болон сөрөг талын зардал, үр өгөөжийг хувилбар тус бүрээр харьцуулан үзэж, “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбар нь асуудлыг бүрэн шийдвэрлэх үр дүнтэй гарц гэж дүгнэлээ.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Хууль, тогтоомж боловсруулах аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа. Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө:

Хүний эрх, эрх чөлөөнд сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар	
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх				
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг байхгүй	нөлөө
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг байхгүй	нөлөө
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Сөрөг байхгүй	нөлөө
	1.2.Оролцоог хангах				
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Сөрөг байхгүй	нөлөө
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Сөрөг байхгүй	нөлөө
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага				
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Сөрөг байхгүй	нөлөө
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Сөрөг байхгүй	нөлөө
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Сөрөг байхгүй	нөлөө
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Сөрөг байхгүй	нөлөө
	2.2.Хязгаарлалт тогтоох нь	Тийм	Үгүй	Сөрөг	нөлөө

	зайлшгүй эсэх			байхгүй
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө:

Даатгалын салбарын эдийн засагт үзүүлэх үр нөлөө дунд болон урт хугацаанд сайжрах бөгөөд иргэдийн хувьд даатгуулах сонирхол нэмэгдсэнээр иргэд, аж ахуйн нэгжийн санхүүгийн баталгаа сайжирна.

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
		Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Гадаадын даатгагч нь тодорхой төрлийн даатгалын төрлөөс бусад даатгалын үйл ажиллагааг Монгол Улсад байрлах төлөөлөгчийн газраар дамжуулан үйл ажиллагаа явуулах зохицуулалтыг тусгана.

	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Дотоодод төлөөлөгчийн газраа байгуулан нөөц бүрдүүлснээр гадаад улсын даатгагч дампуурснаас үүсэх төлбөрийн чадвартай холбоотой эрсдэл буурна.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй

	бий болгох эсэх			
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Даатгуулагч нөхөн төлбөр гаргуулах процессыг хялбаршуулна.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Даатгалын үйл ажиллагаа зохистой түвшинд хүртэл хөгжсөнөөр хувь хүнд тулгарах гэнэтийн санхүүгийн хүндрэлээс сэргийлэх боломж бүрдэнэ.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй

	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, зохицуулалтыг боловсронгуй болгоно.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Даатгалын үйл ажиллагаа зохистой төвшинд хүртэл хөгжсөнөөр зах зээлийн тогтвортой хөгжилд томоохон түлхэж болно.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй

4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө:

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах үйл ажиллагаа хялбар болсноор даатгалын үйл ажиллагаанд итгэх иргэдийн итгэл, даатгуулах сонирхол нэмэгдэнэ.

Үзүүлэх нөлөө	Үр	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл		1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
		1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
		1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
		1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх		2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
		2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
		2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
		2.4.Шинээр ажлын стандарт	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй

	гаргах эсэх			
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, зохицуулалтыг боловсронгуй болгоно.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Шүүхийн өмнө маргаан шийдвэрлэх тогтолцоог сайжруулна.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд,	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй

боловсролын систем	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй

4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө:

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй

	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй

4.5.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх:

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд бүрэн нийцэх бөгөөд бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй, давхардахгүй болно.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын Тав дахь хэсэгт заасан үе шатанд хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг тандан судлахад:

- Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй;
- Хүний эрхэд сөрөг нөлөө үзүүлэхгүй, харин даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог сайжруулах буюу эерэг нөлөөтэй;
- Даатгалын салбарын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах, түүний хяналт шалгалтыг олон улсын практик туршлага, стандартад нийцүүлэн боловсронгуй болгох, сайжруулах, даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах, ингэснээр улс орны нийт эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх эерэг нөлөөтэй;
- Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх бөгөөд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бусад хууль тогтоомжийг аливаа хэлбэрээр зөрчөөгүй бөгөөд Үндсэн хууль болон бусад хуулийн зүйл, заалт, зорилттой нийцэхээр байна.

ЗУРГАА. ТУХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

А.Бусад улс орны хуулийн онцлох зохицуулалтууд^{31, 32, 33}

Герман улс

Герман улсын хувьд даатгалын салбарыг зохицуулах гол хуулиуд нь Даатгалын хяналтын тухай болон Даатгалын гэрээний тухай хууль юм.

Insurance Supervision act /Даатгалын хяналтын тухай хууль/

Даатгалын компаниуд Герман улсад үйл ажиллагаа явуулахын тулд зөвшөөрөл авах шаардлагатай байдаг бөгөөд Европын холбооны бусад оронд зөвшөөрөл авсан даатгагч нь тухайн улсад үйл ажиллагаа явуулахад зөвшөөрлийг давхар авах шаардлагагүй байдаг байна.

Даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг зөвхөн олон нийтийн хязгаарлагдмал хариуцлагатай компани, хамтын сан, нийтийн эрх зүйн байгууллагууд авах боломжтой бөгөөд үүнд даатгалын бүтээгдэхүүний бизнес төлөвлөгөө, давхар даатгалын бодлого, хангалттай нөөц сангийн баталгаа /даатгалын төрлөөс хамаардаг/ болон бизнес, борлуулалтын үйл ажиллагаа явуулах хөрөнгийн мэдээллийг бүрдүүлэх шаардлагатай. Мөн 2 болон түүнээс

³¹ Law Business Research Limited, Getting the Deal Through, Insurance and Reinsurance, 2018

³² Norton Rose Fulbright, 2018:Insurance regulation in Asia Pacific, 2018

³³ ICLG, Insurance and reinsurance, 2018

дээш тооны удирдах ажилтнуудыг тухайн бизнесийг явуулах зохих чадвартай, байхыг шаарддаг.

Даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг давхардуулан олгодоггүй байна. Тухайлбал, амьдралын даатгалын компани ердийн даатгал буюу хөрөнгийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг авах боломжгүй байдаг.

Даатгагч нь даатгалын бус бизнесийн үйл ажиллагаа явуулахаас зайлсхийх ёстой.

Зохицуулах байгууллага нь даатгагчийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил дутагдлыг арилгуулах даалгавар өгөх эрхтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг цуцалдаг. Түүнчлэн даатгагчийн эрх бүхий албан тушаалтан нь анхаарал, хариуцлагагүй ажилласан тохиолдолд тухайн ажил эрхлэхийг хориглох эрхтэй байдаг.

Insurance contracts Act /Даатгалын гэрээний тухай хууль/

Даатгалын гэрээний тухай хууль нь “хэрэглэгчийг хамгаалах суурь стандарт”-ыг тогтоосон байдаг. Зөвхөн зарим нэг тодорхой эрсдэлийн хувьд /агаарын хөлгийн, хөлөг онгоцны, тээвэрлэгдэх барааны, газрын тээврийн хариуцлагын, агаарын хөлөг болон усан онгоцны хариуцлагын/ хуульд зааснаас өөрөөр гэрээ байгуулахыг зөвшөөрдөг.

Даатгалын гэрээний тухай хуулиар усан тээвэр болон давхар даатгалыг зохицуулаагүй байдаг тул дээрх харилцаанд Германы Иргэний хуулийг дагаж мөрддөг байна.

2008 онд хийсэн хуулийн шинэчилсэн найруулгаар гэрээ байгуулахаас өмнө даатгуулагчийг даатгалын ерөнхий нөхцөл, заалт зэрэг холбогдох мэдээллээр хангахыг даатгагчид үүрэг болгосон. Ингэснээр даатгуулагч нарт мэдээлэлд үндэслэн шийдвэрээ гаргах боломжийг бүрдүүлсэн. Даатгуулагчийн бүрдүүлсэн өргөдлийн нөхцөл, заалтуудад даатгагч зарим нэг өөрчлөлтийг оруулж болох боловч түүнийгээ даатгуулагчид мэдэгдэх ёстой байдаг. Тус мэдэгдлийг зохих журмын дагуу хүргүүлээгүй бол даатгуулагчийн тавьсан нөхцөл, заалтууд хүчин төгөлдөр гэж үздэг байна.

Мөн даатгагч нь гэрээ байгуулахаас өмнө даатгуулагчийн хэрэгцээ шаардлагыг тодруулж, зөвлөгөө өгөх үүрэгтэй бөгөөд түүнийгээ баримтжуулах ёстой байдаг. Нийтийн эрх зүй бүхий орнуудаас ялгаатай нь даатгуулагч нь тухайлсан асуулт, тодруулга тавиагүй тохиолдолд даатгагчид эрсдэлтэй холбоотой мэдээллийг өгөх шаардлагагүй байхаар хуульчилсан. Харин усан тээвэр болон давхар даатгал нь өөр хуулийн хүрээнд зохицуулагддаг тул чухал мэдээллийг даатгуулагч өөрөө гаргаж тавих зарчим үйлчилдэг. Мөн томоохон эрсдэл болон нээлттэй даатгалын гэрээнд зарим нэг шаардлагыг хангахгүй байж болохоор тусгасан байна.

Даатгуулагч нь даатгагчид худал мэдээлэл өгч даатгалын гэрээг байгуулсан нь батлагдвал даатгагч гэрээг хүчингүй болгохоос гадна даатгалын тохиолдлыг шалгах, нягтлах зэрэг зардлыг нэхэмжлэх эрхтэй байхаар зохицуулсан байна.

Даатгалын гэрээний тухай хуулиар доорх гэрээнүүдийн агуулга, онцлог нөхцөл, хэм хэмжээг тусгайлан зохицуулсан байдаг. Үүнд: хөрөнгийн, хариуцлагын

болон албан журмын, хуулийн зардлын, тээврийн, барилгын галын, амьдралын даатгалын, ажлын байрны ослын, гэнэтийн ослын, эрүүл мэндийн даатгалын гэрээ зэрэг болно.

Австрали улс

Австрали улсын хувьд даатгалын салбарыг зохицуулах гол хуулиуд нь Даатгалын тухай, Амьдралын даатгалын тухай, Хувийн эрүүл мэндийн даатгалын тухай болон Даатгалын гэрээний тухай хууль юм.

Insurance act /1973/ нь ердийн даатгалын үйл ажиллагааг зөвшөөрлийн үндсэн дээр явуулах, зөвшөөрөл авах талаар зохицуулсан бол **Life Insurance act /1995/** нь амьдралын даатгалын үйл ажиллагаа явуулах этгээд бүртгүүлэх, бүртгэл хийлгэх талаар зохицуулсан байдаг.

Австрали улсад гадаадын даатгалын компани даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагаа явуулахыг хориглодог боловч зарим үйл ажиллагааг зөвшөөрөлгүй даатгагч хэрэгжүүлж болохоор заасан. Үүнд:

- Даатгуулагч нь “өндөр үнэлгээ бүхий” гэрээ байгуулахад /журамласан/
- Энгийн бус /ховор/ эрсдэлүүдийн гэрээ
- Австрали улсад байгуулах боломжгүй гэрээ
- Гадаад улсын хуулийн дагуу тус улсад зөвшөөрөл авсан даатгагчаар даатгуулах шаардлагатай гэрээ

Ердийн болон амьдралын даатгалын үйл ажиллагаа эрхлэгчдэд зохицуулах байгууллагаас мөрдүүлэх журам стандартыг тавьж, хяналтыг хэрэгжүүлдэг. Зохицуулах байгууллага нь даатгагчийн хөрөнгийн доод хэмжээ, давхар даатгалын удирдлага, эрсдэлийн удирдлага, аутсорсинг болон компанийн засаглал зэрэг стандартуудыг баталдаг.

Компанийн тухай хууль /Corporations act 2001/-ын дагуу ердийн болон амьдралын даатгалын тодорхой бүтээгдэхүүний нэгдсэн зөвшөөрөл, ил тод байдал болон даатгалын үйл ажиллагаа эрхлэх шаардлагуудыг тусгасан байдаг. Австрали улсад аливаа санхүүгийн үйл ажиллагаа явуулах этгээд тус хуулийн дагуу санхүүгийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

Австрали улсад эрүүл мэндийн даатгал, ердийн болон амьдралын даатгалын зохицуулалтууд нь ялгаатай байдаг бөгөөд эрүүл мэндийн даатгалын хувьд **Private health insurance act /2007/, Private health insurance (Prudential supervision) /2015/-**ын хүрээнд зохицуулагддаг. Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа явуулах этгээд нь зохицуулах хороонд бүртгүүлэх шаардлагатай бөгөөд дээрх хуулийн онцлог нь Засгийн газраас хэрэгжүүлдэг Medicare /эрүүл мэндийн даатгалын хөтөлбөр/-тэй уялдуулсан байдаг оршино.

Харин Даатгалын тухай хууль /Insurance contract act 1984/ нь даатгалын гэрээний харилцааг зохицуулдаг ба гэрээнд оролцогч талууд шударга байх, чухал шаардлагатай мэдээллийг гаргах, худал мэдүүлэхийг хориглох үүргийг тусгасан байдаг.

Даатгалын болон давхар даатгалын гэрээтэй холбогдох харилцаа нь гэрээний тухай ерөнхий хууль болон нийтийн эрх зүйн хүрээ /цөөнгүй нь Нэгдсэн Вант Улсын шүүхийн практик/-аар зохицуулагддаг. Гэхдээ зарим нэг асуудлыг

Insurance Contracts Act болон бусад хуулиар зохицуулдаг. Даатгалын гэрээний хэв шинжийг хуулиар тухайлан заагаагүй байдаг ба шүүхээр гэрээнд тусгах шаардлагатай асуудлуудыг тодорхойлсон байдаг. Үүнд:

- Даатгуулагч нөхөн төлбөр авах эрхтэй байх
- Даатгагч нь гэрээнд заасан даатгалын тохиолдол учрахад нөхөн төлбөр олгох үүрэгтэй байх
- Даатгалын тохиолдол болох эсэх мөн цаг хугацаа нь урьдчилан харах боломжгүй байх
- Дийлэнх тохиолдолд даатгалын гэрээний хураамжийн төлбөртэй байх зэрэг болно.

Insurance Contracts Act-ын дагуу талууд нь шударга, нэгнээсээ чухал шаардлагатай мэдээллийг нуух, худал мэдүүлэхийг хориглох үүргийг тухайлсан байдаг. /Duty of utmost good faith/

Мөн даатгуулагч нь даатгагчийн шийдвэр гаргалтад нөлөөлөхүйц чухал мэдээллийг гаргаж өгөх шаардлагатай байдаг. /Duty of disclosure/

Хуулийн дагуу гэрээний бүхий л зүйлийг тусгасан баримтыг бичгээр даатгуулагчийн хүсэлтээр гаргаж өгөх үүрэгтэй байдаг. Давхар даатгалын хувьд APRA гаргасан стандартыг баримтлах ёстой.

Япон улс

Япон улсын хувьд даатгалын салбарыг зохицуулах гол хуулиуд нь Даатгалын бизнесийн тухай болон Даатгалын тухай хууль юм.

Даатгалын бизнесийн тухай хууль

Тус хуулиар Япон улсад даатгал, давхар даатгалын үйл ажиллагааны хяналт, холбогдох журмуудыг тусгасан. Даатгалын бизнесийн тухай хуулийн дагуу Япон улсад үйл ажиллагаа явуулах даатгал, давхар даатгалын компаниуд нь Япон улсад салбараа байгуулж, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан байхыг шаарддаг. Гэхдээ дор дурдсан даатгалын гэрээг зөвшөөрөлгүй гадаадын даатгагч байгуулж болдог. Үүнд:

- Давхар даатгал
- Олон улсын ачаа тээвэр
- Хилийн чанад дахь аяллын даатгал
- Даатгуулагч нь FSA-аас зөвшөөрөл авсан тохиолдол

Даатгалын тухай хууль

Тус хуулиар даатгалын гэрээний хэм хэмжээг зохицуулсан. Даатгалын гэрээнд тусгагдах ёстой үндсэн агуулга, даатгагчид мэдээлэл гаргаж өгөх үүрэг, гэрээний бүртгэл зэрэг асуудлыг нарийвчлан тусгаж өгсөн байна.

Хуулиар даатгуулагч нь даатгагчид эрсдэлтэй холбоотой мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй байхаар заасан. Хуулийн дагуу даатгуулагчийн эрхийг хамгаалах зорилго бүхий заавал тусгах шаардлагатай заалт болон гэрээнд тусгах шаардлагатай нөхцөлүүдийн талаар дурдсан байдаг. Даатгуулагчийн эрх ашгийг

хамгаалах зорилго бүхий заалтуудыг мөрдөхгүй байж болох гэрээнүүдийг тусгайлан зааж өгсөн байдаг бөгөөд үүнд:

- Усан тээврийн даатгал
- Агаарын хөлөг, агаарын ачааны даатгал
- Цөмийн үйл ажиллагааны даатгал
- Бизнесийн үйл ажиллагааны даатгал орно.

Даатгалын тохиолдол гарсан үед даатгуулагч нь даатгагчид шуурхай мэдэгдэх үүрэгтэй бөгөөд эс үйлдлээс шалтгаалсан нэмэгдэл хохирлыг нөхөн төлбөрөөс хасах, хоцрогдуулснаас шалтгаалсан зардлыг даатгуулагчаас гаргуулах эрхтэй болдог.

Гэрээг баталгаажуулахад даатгалын гэрчилгээг даатгуулагчид өгөх ёстой бөгөөд үүнд ерөнхий мэдээллийг тусгасан байхыг шаарддаг байна.

Б.Өөрийгөө зохицуулагч байгууллага

• Филиппин улс

Филиппин улс 1974 онд батлагдсан Даатгалын тухай хуульдаа 2012 онд нэмэлт, өөрчлөлт оруулж өөрийгөө зохицуулагч байгууллагын талаар зохицуулалтыг тусгасан байна. Тус хуулиар өөрийгөө зохицуулагч байгууллагад тавигдах шалгуур, хэрэгжүүлэх чиг үүрэг, эрх хэмжээ зэргийг тусгайлан тусгасан байдаг байна. Мөн өөрийгөө зохицуулах чиг үүрэг бүхий даатгалын мэргэжлийн холбоод нь нэгдсэн мэдээллийн сан хөтлөх, зарим төрлийн хураамжийн хэмжээг тогтоох эрхтэй байдаг ба төрийн зохицуулагч байгууллагатай холбоотой ажилладаг. Мөн хуулиндаа хариуцлага, зөрчилд хүлээлгэх арга хэмжээг дурдсан ба нарийвчилсан бүтэц, эрхлэх үйл ажиллагааг дэлгэрэнгүй тусгаагүй байна.

• Казакстан улс

Казакстан улсын Даатгалын тухай хуульд Актуарчдын холбоог шууд өөрийгөө зохицуулагч байгууллага байхаар тусгасан ба байгууллагын эрх үүрэг, бүтэц, үйл ажиллагааны чиглэл зэргийг дэлгэрэнгүй тусгасан. Тухайлбал:

- Даатгалын төрөл, хэлбэр, төлбөр, хураамжийн хэмжээнд үндэслэн актуар тооцооллын чиглэлээр байнгын судалгаа хийх
- Холбогдох хуулиудын хүрээнд даатгалын гэрээнд тусгагдах илтгэлцүүрүүдийг шинэчлэх, дүн шинжилгээ хийх
- Сургалт зохион байгуулах
- Гишүүдийн хүрээнд мөрдөгдөх дүрэм, журам, стандарт, ёс зүйн дүрэм боловсруулж батлуулах
- Гишүүдийн хүрээнд маргаан хянан, шийдвэрлэх зэрэг эрх үүрэгтэй байхаар хуульчлагджээ.

• БНХАУ

БНХАУ-ын Даатгалын тухай хуульд зааснаар үйл ажиллагаа явуулж буй даатгалын бүх компани, даатгалын төлөөлөгч, брокер, даатгалын үнэлгээний компаниуд зэрэг нь Даатгалын холбоонд гишүүнээр элссэн байхаар тусгасан байна. Даатгалын холбоо нь салбарын өөрийгөө зохицуулагч байгууллагын

статустай байх ба Хятадын Даатгалын зохицуулах хорооноос зөвшөөрөл авч, бүргүүлсэн байх шаардлагатай байна. Холбооны үндсэн үйл ажиллагааг нарийвчилсан журмаар зохицуулсан ба дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг байна:

- **Гишүүн байгууллагууддаа заавар, зөвлөмж өгөх**
- **Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах**
- **Гишүүн байгууллагуудын мөрдөх дүрэм, журам боловсруулах**
- **Шударга өрсөлдөөнийг хангуулах**
- **Салбарын хэмжээнд мөрдөгдөх техникийн үзүүлэлтийн, үйлчилгээний болон холбогдох бусад стандартуудыг тогтоох**
- **Салбарын хэмжээнд судалгаа, шинжилгээ хийж холбогдох илтгэлцүүрүүдийг тогтоох**
- **Хууль тогтоомж, дүрэм журам, даатгуулагчийн эрх ашиг, шударга өрсөлдөөний дүрмийг зөрчсөн этгээдийн талаар мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлж торгуул, шийтгэл хүлээлгэх санал гаргах**
- **Салбарын сургалт, мэргэшлийн үйл ажиллагааг зохицуулах**

В.Даатгалын мэдээллийн нэгдсэн сан

• Япон

GIROJ нь Япон улсын Амьдралын бус даатгалын тухай хуульд заасны дагуу үйл ажиллагаа явуулдаг даатгалын болон давхар даатгалын компаниудыг хамруулсан Санхүүгийн үйлчилгээний агентлагийн зохицуулалтад хамаардаг ашгийн бус байгууллага юм. Тус байгууллагын үндсэн үйл ажиллагаа нь:

- Цэвэр хураамжийн хувь болон нийт хураамжийн хувь зэргийн тооцооллыг боловсруулж, мэдээллээр хангах
- Тээврийн хэрэгслийн албан журмын даатгалын нөхөн төлбөрийн мэдээллийн санг үүсгэх
- Мэдээллийн нэгдсэн сан бий болгож хөтлөх

GIROJ нь гишүүн байгууллагуудаас нийлүүлсэн ихээхэн хэмжээний мэдээллийг нэгтгэн боловсруулж, түүгээр олон талыг хангадаг. Статистикт суурилан цэвэр хураамжийн хувь болон нийт хураамжийн хувийг тооцоолж, актуар тооцоолол болон шинжлэх ухаанд суурилсан аргачлалын /үер, газар хөдлөлт, хар салхины эрсдэлийн модулийг хөгжүүлдэг ба эдгээрийг инженерийн болон шинжлэх ухааны аргачлалын дагуу боловсруулдаг/ дагуу хураамжийн хэмжээг гишүүн байгууллагуудад тогтоож үйлчилдэг.

• Солонгос

Солонгосын даатгалын хөгжлийн институт /KIDI/ нь даатгалын салбарын хөгжлийг дэмжих, даатгагч, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллага юм. KIDI-ээс даатгалын салбарын үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор холбогдох мэдээллийг цуглуулж, мэдээллээр олон талыг хангах, тооцоололд үндэслэн бодит хураамжийн хэмжээг тооцоолох чиг үүргийг гүйцэтгэдэг. Солонгосын Даатгалын тухай хуулиар олгосон эрх үүргийн дагуу зөвхөн KIDI нь салбарын хэмжээний мэдээллийн сан үүсгэн хөтлөн явуулах эрх бүхий байгууллага ба хураамжийн хэмжээ болон актуарын хүснэгтийг тооцоололд үндэслэн боловсруулдаг. Мөн Хураамжийн хэмжээ болон нөөцийн

сангийн хэмжээг шинэ бүтээгдэхүүн болон бодлогын орчинд үндэслэн тооцож салбарын эрүүл өсөлтийг дэмжиж ажилладаг байна.

KIDI-ээс Солонгос улсад үйл ажиллагаа явуулж буй ердийн болон урт хугацааны даатгалын бүх компаниудаас даатгалын гэрээ болон нөхөн төлбөртэй холбоотой мэдээллийг цуглуулж авдаг. Авсан мэдээллийг нэгтгэн боловсруулж даатгалын салбарын статистик мэдээллийг эрсдэлийн төрөл болон чиглэл бүрээр бий болгоно. Эдгээр мэдээллийг институтээс сар болон жил бүрээр нийтэлж ажилладаг байна. Мөн өөрсдийн төрөлжсөн мэдээллийн сангийн ангиллуудаар даатгалын компаниудад андеррайтинг болон хураамжийн хэмжээ тогтоох үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлдэг. KIDI-ийн зүгээс мэдээллийн санд тулгуурлан хураамжийн болон эрсдэлийн тооцооллын мэдээлэл, даатгалын төрөл, бүтээгдэхүүн зэргийн уялдаа холбоотой байдалд үндэслэсэн статистик, дотоодын болон гаднын зах зээлийн харьцуулалт мэдээлэл болон тухайлсан компаниудыг харьцуулсан зэрэг маш олон төрлөөр мэдээллийн санг баяжуулж, үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр нэгдсэн мэдээллүүд нь салбарын хөгжлийг дэмжих, бүтээгдэхүүн хөгжлийг сайжруулах болон компаниудын маркетинг, борлуулалтдаа анхаарах зэрэгт чухал ач холбогдолтой юм.

Г. Даатгалын эрсдэл шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн арга хэрэгсэл /Alternative Risk Transfer/

Хөрөнгийн зах зээлийн тусламжтайгаар дотоодын давхар даатгалын зах зээлийг хөгжүүлэх, түүнчлэн гаднын хөрөнгө оруулагчдыг татах нэг арга зам нь эрсдэл шилжүүлэх уламжлалт бус арга механизм юм. Тухайлбал Олон улсад газар хөдлөлт, хар салхи гэх мэт байгалийн гамшгийн эрсдэлийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр даатгалын салбарт дутагдалтай байдаг тул 1990-д оноос Уламжлалт бус эрсдэлийг шилжүүлэх арга механизм - Alternative Risk Transfer-г ашиглан, даатгалын эрсдэлийг шилжүүлэх давхар даатгагчаас өөр субъект, эрсдэлийг үүрч, санхүүжүүлэх шинэ хөрөнгийн эх үүсвэрийг бий болгож эхэлсэн байдаг. Энэхүү жишгийн дагуу даатгалын эрсдэлд суурилсан үнэт цаас (Insurance linked securities) буюу бонд, үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргах замаар хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгон, даатгалын эрсдэлийг тархаан байршуулж, даатгалын компаниудын эрсдэл даах чадамжийг нэмэгдүүлэх боломжтой байна.

Өөрөөр хэлбэл ART нь даатгагч болон давхар даатгагчдад илүү өргөн эх үүсвэрээс хөрөнгийн дутагдлыг арилгах нөхцөл боломжийг бүрдүүлэхийн сацуу хөрөнгө оруулагчдад өөрийн багцыг сайжруулан эрсдэлийг тараан байршуулахад чухал ач холбогдол оруулдаг байна.

Энэхүү эрсдэлийг шилжүүлэх арга механизм нь 1970 оноос эхлэн 1990 он хүртэлх хугацаанд үргэлжилсэн даатгалын зах зээлийн уналтын үеэс эхлэн хөгжиж эхэлсэн. Дэлхий дахинд 1990 оноос эхлэн тохиолдсон байгалийн онц ноцтой гай гамшиг /хар салхи, газар хөдлөлт гэх мэт/ болон олныг хамарсан террорист үйл ажиллагаанаас үүдсэн их хэмжээний хохирол нь уламжлалт бус эрсдэлийг шилжүүлэх арга хэрэгслүүд, ялангуяа Insurance Linked Securities /IRS/-ийн зах зээлийн хэрэгслүүдийг хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэх шинэ алхмыг эхлүүлсэн байна.

- **Зүүн Өмнөд Ази**

Зүүн өмнөд Азийн улс орнуудын хувьд дээрх чиглэлээр судлахад холбогдох хууль, журмуудыг боловсруулж, мөрдүүлэх, даатгалын хураамжийн хувь хэмжээг тогтоох, даатгалын гэрээний стандарт тогтоох, баталсан дүрэм журмаа мөрдүүлэх хэмжээнд хяналт, шалгалт хийх, мэргэшлийн шалгалт зохион байгуулах, салбарын ёс зүйн дүрэм боловсруулж батлах, төрийн зохицуулагч байгууллагадаа санал дэвшүүлэх зэрэг түгээмэл эрх үүргийг хэрэгжүүлдэг байна.

- **Хонг Конг**

Тус улсын Даатгалын хуулийн 133 дугаар хэсэгт заасны дагуу 2017 оны 6 дугаар сард боловсруулан гаргасан “Давхар даатгалтай холбогдох гарын авлага” /Guidelines on reinsurance/ -д ART-г дор дурдсан утгаар тодорхойлсон байна.

Эрсдэлийг хөрөнгийн зах зээлд шилжүүлэх нь эрсдэл шилжүүлэх зорилгоор тусгайлан байгуулсан “Тусгай зориулалтын аж ахуйн нэгж”-ийг (“Тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл” гэж мөн нэрлэдэг) ("Special Purpose Entity" буюу SPE) дагуулдаг. Аливаа SPE бүтцийн гол элемент бол даатгалын эрсдэлийг "бүрэн санхүүжүүлсэн", "дампуурлаас алслагдсан" тээврийн хэрэгсэлд шилжүүлэх явдал бөгөөд үүгээрээ аливаа хөрөнгө оруулагчдын нэхэмжлэлийг цедантад захируулах ба хөрөнгө оруулагчдын тээврийн хэрэгсэлд учирсан эдийн засгийн хохирол гарсан тохиолдолд уг гэрээнд хандах эрхгүй болно. Ийм тохиолдолд даатгагч эрсдэлийг бууруулахын тулд SPE-ээр дамжуулан оновчтой стратегийг бий болгодог байна.

- **Сингапур**

Сингапур улсын 2018 онд баталсан Даатгалын үйл ажиллагааны 42 дугаар бүлэг буюу Онцгой зорилготой давхар даатгалын этгээд /General provisions and exemptions for special purpose reinsurance vehicles/-д зориулсан ерөнхий зөвлөмжид ILS-тэй холбогдох зүйл заалтуудыг тусгасан байна.

Сингапур нь Ази тивд даатгал, давхар даатгалын тэргүүлэгч зангилаа гэдгээрээ нэлээд хугацаанд хүлээн зөвшөөрөгдсөн билээ. Сүүлийн жилүүдэд (ялангуяа даатгалтай холбоотой үнэт цаас, гамшгийн эрсдэлийн даатгалын талаархи) олон санаачилга нь дэлхийн анхаарлын төвд оруулсан байна.

Сүүлийн жилүүдэд Сингапур улс нь дотоод дахь даатгалтай холбоотой үнэт цаасны (ILS) зах зээлийг янз бүрийн урамшууллын хөтөлбөрөөр хөгжүүлэх чиглэлээр дэвшилтэт алхам хийж байна. Энэ нь хэд хэдэн 'catastrophe bond'-ыг Сингапурын бирж дээр гаргах эсвэл бүртгүүлэхэд хүргэсэн. Жишээлбэл, Филиппиний газар хөдлөлт, халуун орны циклоны эрсдэлийг хамарсан Дэлхийн банкны хөтөлбөрийн хүрээнд гаргасан Ази тив дэх анхны бүрэн эрхт сүйрлийн бондыг Сингапурын бирж дээр 2019 оны сүүлээр гаргасан. Түүнчлэн 2018 оны 12 дугаар сараас 2020 оны 6 дугаар сар хүртэл нийт найман удаа 1 тэрбум ам.доллараас давсан үнэ бүхий 'catastrophe bond'-ыг өөрийн зах зээл дээр гаргасан байна. Сингапурын давхар даатгалын төв болох Ази дахь давамгайлал байр суурийг улам сайжруулахын тулд зохицуулагчид даатгалын салбарт Variable Capital Company (VCC) бүтэц (сангийн менежментийн салбарт 2018 онд нэвтрүүлсэн) гэх мэт шинэ корпорацуудын бүтцийг нэвтрүүлэхээр судалж байна.

Д.Давхар даатгал

- **БНЭУ-ын үндэсний давхар даатгалын корпораци “GIC RE”**

1972 оны ердийн даатгалын бизнесийн тухай хуулиар Энэтхэгийн Засгийн газраас Ердийн даатгалын бүх бизнесийг нийгэмчилж, Энэтхэгийн 55 даатгалын компанийн хувьцаа, бусад ердийн даатгалын 52 компанийн үйл ажиллагааг нийгэмчилсэн.

Энэтхэгийн Ердийн даатгалын корпораци нь энэхүү нийгэмчлэлийн тухай хуулийн 9.1-ийн дагуу байгуулагдсан. Энэтхэгийн ердийн даатгалын үйл ажиллагааг удирдах, хянах, даатгал хийх зорилготойгоор байгуулсан байна.

2000 оны 11 сард GIC Энэтхэгийн давхар даатгагч болсон бөгөөд охин компаниуддаа хяналт тогтоох, зөвлөх эрхгүй болсон. Үүнтэй холбогдуулж 2002 оны Энэтхэгийн ердийн даатгалын бизнесийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. 2003 оны 3 сард энэхүү хууль хэрэгжиж эхэлснээр охин компаниуддаа засгийн газрын мэдэлд шилжүүлсэн. Үүний үр дүнд GIC нь Энэтхэгийн цор ганц давхар даатгалын компани болсон бөгөөд GIC Re хэмээн нэрлэгдэх болсон. Энэтхэгийн даатгалын компаниуд 2013 оны 4 сараас эхлээд бүх даатгалынхаа 5%-ийн энэхүү компанид шилжүүлэх болсон. Одоогоор үйл ажиллагаагаа төрөлжүүлж, SAARC-ийн орнууд, Зүүн өмнөд Ази, Дундад Ази, Европ, Америк, Африкийн орнуудад давхар даатгал хийх болсон. Лондон, Москва, Дубай, Куала Лампурт салбараа нээсэн бөгөөд цаашдаа ч улам өргөжих төлөвлөгөөтэй байна.

- **Беларусийн үндэсний давхар даатгалын компани “BELARUS Re”**

Беларусын үндэсний давхар даатгалын компани нь 2006 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр Сайд нарын зөвлөлийн шийдвэрээр байгуулагдсан. Беларусь улсын хууль тогтоомжийн дагуу тус улсын нутаг дэвсгэр дээр давхар даатгалын эрсдэлтэй холбоотой гадаадын даатгалын болон давхар даатгалын байгууллагуудтай хамтран ажилладаг цорын ганц компани юм.

Давхар даатгалын компанийг байгуулах үндэслэл нь нэгдүгээрт, үндэсний хүчин чадлыг давхар даатгалаар харуулах, мөн гадаад руу гарах валютын урсгалыг багасгах, хоёрдугаарт, далд давхар даатгалын тогтолцоог арилгах зорилгоор байгуулсан. Беларусь улсын хуульд зааж өгсний үр дүнд бүх давхар даатгалын гэрээ тус байгууллагаар дамждаг болж хяналт хийгдсэний дагуу Үндэсний давхар даатгалын нэгдсэн тогтолцоог бий болгож чадсан байна. Мөн улсын эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалах, дотоод, гадаадын хуулийн этгээд хувь хүний үл хөдлөх хөрөнгийн ашиг сонирхлыг хамгаалахад давхар даатгал руу чиглэсэн төрийн бодлого хэрэгжүүлсэн байна.

Төрийн өмчит компанийн үндсэн үүрэг нь даатгалын болон давхар даатгалын үйл ажиллагааг эрхлэх, Беларусь улсын нутаг дээр үйл ажиллагаагаа явуулж байгаа даатгалын компаниуд болон давхар даатгалын гэрээнд хяналт тавих үүрэгтэй юм. Даатгалын компаниуд Сангийн яамнаас тогтоосон журмыг мөрдөх шаардлагатай гэж тусган тухай бүрчлэн журам гаргадаг. Тухайлбал, Даатгалын компаниуд хуулиар тогтоосон хариуцлагын хэмжээнээс хэтэрсэн эрсдэлийг шилжүүлэхдээ “Беларусын Үндэсний давхар даатгалын компани”-тай гэрээ байгуулах замаар давхар даатгуулах 10 хувийг шилжүүлэх; Даатгалын компаниуд сайн дурын даатгалын гэрээний дагуу хуулиар тогтоосон хариуцлагын хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд зөвхөн улсын аж ахуй нэгжид тухайн хэтэрсэн хэмжээг давхар даатгуулах; гэж тусгасан байдаг байна.

- **Оросын холбооны улсын үндэсний давхар даатгалын компани “РНПК”**

ОХУ-ын эсрэг хориг арга хэмжээнүүд үргэлжилсэн энэ үед даатгалын салбар эрсдэлтэй байдалд орж эхэлсэн байна. Үндэсний давхар даатгалын компани байгуулснаар ОХУ-ын давхар даатгалын зах зээлийн чадавхыг эрс нэмэгдүүлэх, мөн ОХУ-д тавьж байгаа хориг арга хэмжээний улмаас эрсдэлээ гаднын компанид даатгах боломжгүй болсон даатгалын компаниудын хамгаалалтыг баталгаажуулах боломжтой байгаа гэж үзсэн байна. Эдийн засгийн хүндрэлтэй байгаа Орос орны хувьд Үндэсний давхар даатгалын компанийг байгуулснаар гадагшаа гарах валютын урсгалыг багасгах, гадаадын давхар даатгалын компанид даатгуулж байгаа мөнгийг дотооддоо авч үлдэх гээд олон эерэг талыг үндэслэсэн байна.

2014 оны байдлаар ОХУ-ын даатгалын зах зээлийн хэмжээ 138,5 тэрбум рубль байсан бол, үүнээс 100 тэрбум рубль гаднын давхар даатгалд шилжигдсэн байна. Сүүлийн 3 жилийн байдлаар олон улсын давхар даатгалын хураамжийн хэмжээ 260 тэрбум рубль давсан гэсэн тоо баримт байна. Харин гаднаас ОХУ-д орж байгаа давхар даатгалын хураамжийн хэмжээ ердөө 40 тэрбум рубль байгаа юм. Иймээс үндэсний давхар даатгалын корпорац байгуулснаар нэг талаас ОХУ-аас гарч байгаа гадаад валютын урсгалыг багасгах, нөгөө талаас олон улсын зах зээлээс ирж байгаа хөрөнгийг нэмэгдүүлэх болно гэж үзжээ.

“Үндэсний Давхар Даатгалын компани” /цаашид “ҮДДК” гэх/ нь даатгуулагчдыг дэмжиж, өмчийн ашиг сонирхлыг хамгаалах, даатгагчдын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, даатгалын зах зээлийн хөгжүүлэх, өсөлтийг эдийн засгийн нэмэгдүүлэх, зорилгын хүрээнд зохион байгуулалтын хууль эрх зүйн хувьд хувьцаат компанийн хэлбэрээр байгуулагдсан. Үндэсний Давхар даатгалын компанийг 2016.07.03-ны өдөр “ОХУ-д даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, 363 тоот холбооны хуулиар батлан үүсгэн байгуулж, түүний хувьцааг 100 хувь Оросын Төв Банканд эзэмшүүлэхээр заасан. Уг хууль нь 2017.01.01-ний өдөр хүчин төгөлдөр болж эхэлсэн. Ийнхүү Оросын Үндэсний Давхар даатгалын компанийн үндсэн хөрөнгийг Оросын Төв Банкны шийдвэрээр 71 тэрбум рубль байхаар заасан бөгөөд өнөөдрийн байдлаар хөрөнгийн 30%-ийг буюу 21,3 тэрбум рублийг шилжүүлсэн байна.

Давхар даатгуулагч (даатгагч) нь үндсэн даатгалын гэрээ байгуулсны дагуу даатгалын нөхөн төлбөрийн үүргийг “ҮДДК”-ийн давхар даатгалд шилжүүлэх үүрэгтэй, тэр дундаа албан журмын давхар даатгалын гэрээ байгуулсан нөхцөлд 10%-ийн шимтгэлийг давхар даатгалд шилжүүлэх нөхөн төлбөрийн үүргээс шилжүүлэх үүрэгтэй гэж заасан байна.

**ГАДААД ОРНУУДЫН ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТАЛААР ХИЙСЭН СУДАЛГААНЫ
МАТРИКС**

Орон	Компани	Байгуулагдсан огноо	ҮДДК болсон	Зорилго, үүрэг	Өмчийн хэлбэр	Холбогдох хууль тогтоомж	Хөрөнгө	Салбар нэгж	Нэмэлт мэдээлэл
ОХУ	Үндэсний давхар даатгалын компани	2016	2017	Гаднын улсуудын хориг арга хэмжээний улмаас гадаадын давхар даатгалд эрсдэлээ даатгах боломжгүй болсон даатгалын компаниудын хамгаалалтыг хийж, гадагшаа гарах валютын урсгалыг бууруулах, мөнгөний урсгалын дотооддоо авч үлдэх зорилгоор байгуулагдсан.	Төрийн өмчит компани-Төв банк 100% хувьцааг эзэмшинэ	Үндэсний давхар даатгалын компани байгуулах тухай даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан.	1,1 тэрбум доллар	Салбар байхгүй.	ОХУ-ын хуульд заасны дагуу даатгалын компаниуд эрсдэлийн 10%-ийг заавал даатгуулах юм. Нэг даатгалын тохиолдолд 80 хүртэл сая ам.долларын эрсдэлийг хариуцна.
БНХАУ	China Re	1949	2003 – China Re group	Давхар даатгалын салбарыг бий болгож, хөгжүүлэх, улмаар нийгэм эдийн засгийн салбарыг хөгжүүлэх зорилгоор байгуулагдсан.	Төрийн өмчит давхар даатгалын цор ганц групп.	БНХАУ-ын анхны даатгалын тухай хууль- 1995	5,5 тэрбум ам.доллар	Гадаадад салбар байхгүй. 6 охин компанитай	2003 онд China Re групп болж, урт хугацааны болон ердийн даатгалаар бие даасан үйл ажиллагаа эрхлэх болсон. 2007 онд China Re ХХК болж өөрчлөгдсөн.
Беларусь	Belarus Re	2006	2006	Ил тод бус байгаа давхар даатгалын тогтолцоог арилгах, үндэсний давхар даатгагчийг чадавхжуулах, гадаад руу гарах валютын	Төрийн өмч-Хувьцаа эзэмшигч нь сангийн яам	Даатгалын үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Беларусын үндэсний давхар даатгалын компани	23,64 тэрбум ам.доллар	Гадаад улсад салбар байхгүй.	Үндэсний давхар даатгуулагчид даатгуулах хувийг хуульд тусгасны үр дүнд бүх давхар даатгалын гэрээ тус байгууллагаар

				урсгалыг багасгах зорилгоор байгуулагдсан.		байгуулах тухай Сайд нарын зөвлөлийн тогтоолын дагуу байгуулагдсан.			дамждаг болж, хяналт хийгдсэний дагуу Үндэсний давхар даатгалын нэгдсэн тогтолцоог бий болгож чадсан байна. 2006 онд 10 хувь байхаар хуульд заасан бөгөөд цаашид 100% болгох төлөвлөгөө байна.
Филиппин	Philnare	1977	2007-Үндэсний хэмжэний давхар даатгалын корпораци	Филиппин болон хөрш улсуудын зах зээлд амьдралын болон ердийн давхар даатгалын үйлчилгээ үзүүлэх, Үүрэг: Даатгалын салбарын хөгжлийг дэмжиж, улсын хэмжээнд бизнесийн хамгаалалт бий болгох, Филиппиний даатгалын компаниудыг давхар даатгаж дэмжих	Нээлттэй хувьцаат компани	1977 оны ерөнхийлөгчийн 1270 дугаар зарлиг, компанийн сайн засаглалын удирдамж	3,9 тэрбум песо буюу 80,7 сая ам.доллар	Салбар байхгүй	2003-2007 оны хооронд 4 үечлэлээр хөрөнгөө ихэсгэсэн.. Олон улсад +ВВ буюу сайн гэсэн үнэлгээ авсан.
Энэтхэг	GIC Re	1972-(GIC)	2000-GIC Re	Энэтхэгийн ердийн даатгалын үй ажиллагааг удирдах, хянах , даатгал хийх	Төрийн өмч	Ердийн даатгалын бизнесийн тухай хууль- 1972, Даатгалын тухай хууль- 1938, Ерөнхий даатгалын бизнесийн тухай хуулийн нэмэлт-2002, Даатгалын зохицуулалт, хөгжлийн удирдлагын тухай хууль- 1999,	12,7 тэрбум ам.доллар	Лондон, Москва, Дубай, Куала Лампурт байдаг. Энэтхэгт 4 охин компани татай.	Энэтхэгийн давхар даатгалын компаниуд давхар даатгалынхаа 5 хувийг заавал шилжүүлэх болсон. Энэтхэгийн цор ганц давхар даатгалын компани. Дэлхийд 14-т жагсдаг.

						Ассоциацийн тухай санамж бичиг			
БНСУ	Korean Re	1963	1978- Korean Re	Даатгалын компаниудын хөрөнгийг өсгөх, давхар даатгалын хураамжийн гадаад урсгалыг зогсоож, улмаар эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор байгуулав.	Төрийн өмчит. Хувь нийлүүлэгч нь сангийн сайд	БНСУ-ын давхар даатгалын тухай хууль- 1962	2,653 тэрбум ам. доллар	Салбар байхгүй	Ази тивд тэргүүн байр, дэлхийд 9-т жагсдаг.
Казакстан		Хамгийн том 5 даатгалын компани нийт зах зээлийн 37 хувийг эзэлдэг. Давхар даатгалын хураамжийн 80% нь гадаадын давхар даатгалд шилждэг байв. Дотоодын дээрх 5 даатгалын компанид давхар даатгуулах санал тавиад, тэднээс татгалзсан хариу авбал гаднын давхар даатгалын компанид даатгуулдаг. 2012 онд гадаадад гарч буй валютын урсгалыг багасгах зорилгоор давхар даатгалын хураамжийн 40 хувь, нийт даатгалын хураамжийн 25 хувийг гаднын давхар даатгагчид шилжүүлэхийг хориглосон. Дээрх нөхцөл бүрдэх шалтгаан нь дотоодын даатгалын зах зээлд давхар даатгалын андеррайтинг хийх чадвартай даатгагч нар олон байдагт оршино.							

ДОЛОО. Зөвлөмж

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан даатгалын салбарыг хөгжүүлэх зорилттой уялдуулан даатгалын салбарт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэх, даатгагч, даатгуулагчийн эрх ашгийг тэнцвэржүүлэх зорилгын хүрээнд урьдчилан тандан судлах ажиллагааг гүйцэтгэсэн бөгөөд харьцуулалтын үр дүнгээр “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбар нь зорилгод хүрэх боломжтой оновчтой хувилбар гэж дүгнэж байна.

---o0o---